

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7 – 50

1.	<i>“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	8 – 10
2.	<i>Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	10 – 48
3.	<i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал</i>	48 – 50

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 15 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Б.Баярбаатар;
Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, О.Номинчимэг,
О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Э.Одбаяр.

Нэг. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Сандаг-Очир: “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Н.Номтойбаяр, Ц.Туваан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх Б.Энхсайхан, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Г.Дарханчулуун, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Хосбаяр, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Үнэнбат, мөн хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Н.Мөнхзэсэм, С.Энхцэцэг, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, С.Зулпхар, С.Эрдэнэболд, Б.Батбаатар, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, О.Алтангэрэл нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: 1.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Ц.Туваан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.“Хархорум хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.“Хархорум хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай эсэх асуудлыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 14 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 45 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
13 цаг 15 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Ирцийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн, Жудагийн Баярмаа, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Лувсаннъямын Гантөмөр, Тогмидын Доржханд, Сархадын Зулпхар, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирц 60 хувьтай болсон байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжуулэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024 оны 12 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хоёр.Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Засгийн газар 2024 оны 12 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудал батлагдлаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх,
түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим
арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр
өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Нэг. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжихүүлэх түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд танилцуулгыг танилцуулна.

С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэр бүхий 101 гишүүний хамтаар санаачилж байгаа юм.

Жамсрангийн Самбуу хэмээх энэ хүн Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар 18 жилийн туршид ажилласан.

1895 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Түшээт хан аймгийн, одоогийн Төв аймгийн Бүрэн сумын “Гурванхүрийн дэнж” хэмээх газарт төрсөн байгаа.

Тэгээд энэ хүний хувьд гурван том хүн үндэслэл байгаа.

Нэгдүгээрт, Дэлхийн II дайн болон хүйтэн дайны жилүүдэд Монгол төрийн бодлогыг хатамжилж, Монголын төрийн хар хүн, түүний хичээл зүтгэл, хувийн шуналаас ангид, төр олон нийтийн үйл хэргийг хэрхэн авч явах тухай маш том үнэ цэнтэй хувь нэмэр, байр суурь, суртахууныг бий болгосон.

Гадаад харилцаа, дипломатын салбарт үнэ цэнтэй хувь нэмэр оруулагч, энхийн төлөө үйлстэн. Мөн хөдөө аж ахуй, тэр тусмаа малчдад чиглэсэн олон олон бүтээлүүдийг туурвиж байсан ийм хүн байгаа.

Тэгээд энэ хүний хувьд ер нь орчин үед authentic leadership буюу жинхэнэ манлайлал гэдэг ойлголт Харвардын судлагдахуунд хүртэл байгаа.

Тэгэхээр бид өнгөрсөн түүхээ аль нэгэн улс төрийн шалгуураар ч гэдэг юм уу, цаг төрийн шалгуураас нь илүү Монголын төрийн алтан аргамжийг хатамжилж явахад үнэ цэнтэй хувь нэмэр оруулсан өтгөс буурлуудаа хүндэтгэж, тэгээд тэр хүмүүсийн төрийг барих ёс суртахуун, төрийг барих тэр гүн ухаанаас нь хойч үедээ сурталчлах, таниулах чиглэл дээр Монголын төр алтан аргамжийн бодлогодоо авч явах ёстой гэж үзсэн.

Ж.Самбуу гуай 1972 оны 5 сар хүртэл 77 наслаад нас бартлаа одоогийн парламентын спикер буюу Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байсан хүний хувьд энэ хүний туулсан амьдрал, бүтээсэн бүтээл Монгол орны төрийг засах үйл хэрэгт оруулсан олон олон үнэ цэнтэй хувь нэмэр нь олон олон судалгааны бүтээл болсон.

Ингээд ирэх жил энэ хүний мэндэлсний 130 жилийн ойг тохиолдуулаад тогтоол гарч, улмаар энэ тогтоолын дагуу эрдэм шинжилгээний хурал, дээрээс нь баримтат нэвтрүүлэг, мөн ном бүтээлийг нь гаргах зорилгоор, алдаршуулах зорилгоор энэхүү тогтоолыг санаачилж Улсын Их Хурлын нэр бүхий 101 гишүүн гарын үсэг зурсан байгаа.

Тэгээд энэ тогтоол дээр холбогдох байгууллагуудаас болон яамдаас санал авсан.

Тэгээд өчигдөр бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ч.Ариунхур болон Ерөнхийлөгчийн Тамгын газартай бид зөвшилцөөд тогтоол дээрээ Засгийн газарт ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай чиглэл өгсөн байдлаар редакцын найруулгыг нь бас засъя гэж тохирсон.

Ингээд Засгийн газраас яг энэ хууль журмынхаа дагуу ойг тэмдэглэн өнгөрүүлэх нарийн товыг Засгийн газрын тогтоолоор тогтоохоор болсон байгаа юм.

Тэгээд хуулийн иж бүрдэл талаасаа бүх зүйл бүрдсэн байгаа. Тэгээд тогтоол болон хуулийн төсөлд тавигдах бүх шаардлагууд хангагдсан байгаа.

Ингээд эрхэм Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд Та бүхнийг энэхүү тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаар дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: С.Эрдэнэболд гишүүнд баярлалаа.

Төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Асуулт асууж, үг хэлж дууслаа.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууссантай холбогдуулаад хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

15 гишүүнээс 8 гишүүн дэмжсэн.

Дээр нь О.Алтангэрэл гишүүн дэмжсэнд тооцоорой гэж байна. Н.Номтойбаяр гишүүн дэмжсэнд тооцоорой гэсэн саналаа өгсөн байна.

Ингээд хувь өөрчлөгдөх юм байна. Ц.Туваан гишүүн бас дэмжсэнд тооцох саналаа өгсөн байна.

Ингээд олонх нь дэмжсэн учраас “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. Гишүүдэд баярлалаа. Хоёр дахь асуудалдаа оръё.

Санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд С.Зулпхар гишүүн танилцуулна.

Хоёр дахь асуудалд оръё.

**Хоёр.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай.

Ажлын хэсгийн гишүүд Б.Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Х.Сүрэнхорол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль зүйн газрын ахлах референт, Н.Нацагдорж “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Б.Энхсайхан “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх,

Г.Дарханчулуун “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Г.Хосбаяр “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Амарсанаа “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн, С.Энхжаргал Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн гэсэн ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийг хэн танилцуулах Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр сайд танилцуулна.

Л.Гантөмөр даргын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хархорин хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн товч танилцуулгыг Та бүхэндээ хийж байна.

Хот байгуулалтын тухай хууль болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1²-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлаас Хархорум хотыг байгуулахаар шийдвэрлэсэн байдаг.

Хот байгуулалтын тухай хууль болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар шинээр хот байгуулах үеийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх, хотын хөгжлийг хэрхэн дэмжих талаар нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд дараах зорилго, зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ, үе шат, хүрэх үр дүнг тодорхойлсон Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна. Үүнд:

Зорилт 8.2-ын хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдүгээр үе шатад Орхоны хөндийд Хархорум хотын байршлийг сонгож техник, эдийн засгийн үндэслэлийг, мөн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.

Гуравдугаар үе шат нь Хархорум хотыг ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын бүтээлч хот болгоно гэж тус тус заасан.

Мөн түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн

нэгд “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтад шаардлагатай суурь судалгаа, бүрэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусгана. Дэд бүтэц, бүтээн байгуулалтын эхний ээлжийн ажлыг эхлүүлнэ. Хархорум хотын усны хэрэгцээ хангах бүтээн байгуулалтыг эхлүүлж, Орхон голд урсцын тохиргоо хийж, усан хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ гэж тусгасны дагуу Засгийн газрын 2023 оны 02 сарын 01-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааг байгуулж, Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах зориулалтаар Архангай аймгийн Өгийнуур, Хашаат сум болон Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт нийт 189 мянга 363 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцлын баталсан зэрэг нь энэхүү хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

Хуулийн төсөлд дараах асуудлуудыг тусгалаа.

1 дүгээр бүлэгт, “Нийтлэг үндэслэл” буюу хуулийн зорилт, Хархорум хотын хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хотын бүтээн байгуулах хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим, хотын эрх зүйн үндэс, байршил, эдэлбэр газар зэрэг асуудлыг тусгав.

Хотын бүтээн байгуулах, хөгжлийг дэмжихэд холбогдох хуульд зааснаас гадна ухаалаг хотыг хөгжүүлэх, олон төвт хотын тогтолцоог бүрдүүлэх, хүмүүнлэг хот байх, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй хот байх, олон төрөлт нийтийн тээвэр, явган алхалт, унадаг дугуй болон цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг дэмжсэн байх гэх мэт хүндээ ээлтэй хот байх зарчмыг баримтална.

2 дугаар бүлэгт, Хот байгуулалтын үйл ажиллагааны тухай буюу Хот төлөвлөлтийн баримт бичиг, хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хотын бүсчлэл, газар зохион байгуулалттай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Хархорум хот нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байх ба хотын газар зохион байгуулалт нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэнэ.

3 дугаар бүлэгт, “ухаалаг хот” буюу хотын хөгжлийг дэмжихэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглахтай холбоотой харилцааг зохицууллаа.

Хот нь оршин суугчдын ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хотын тогтвортой хөгжлийг дэмжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үр нөлөө бүхий ухаалаг хотын төлөвлөлттэй байх ба ухаалаг хотын төлөвлөлтөд

инновац, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

4 дүгээр бүлэгт, хот байгуулалтын удирдлага, зохион байгуулалт буюу хотын чиг үүрэг, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо болон бүрэн эрх, мэдээллийн ил тод байдал зэрэг асуудлыг тусгасан.

Хот нь Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1-д заасан чиг үүргээс гадна өөрийн эдэлбэр газрын хэмжээнд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай чиг үүргийг тодорхойлсон ба Хархорум хотын удирдлагын тогтолцоог хотын зөвлөл, хотын захирагч бүрдүүлэх ба оршин суугчдаасаа сонгогддог байх зарчим баримтална.

Хот нь Шилэн дансны тухай хууль Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаас гадна хотын үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай холбоотой мэдээллийг нээлттэй, ил тод байршуулах юм.

5 дугаар бүлэгт Хархорум хотыг бүтээн байгуулах, хөгжүүлэх үйл ажиллагаанд Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг тусгаж бусад харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

Хархорум хот дахь төрийн үйлчилгээ нь худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, бүртгэл зөвшөөрлийн цахим нэг цонхны үйлчилгээнд суурилсан байх юм.

6 дугаар бүлэгт, хотын эдийн засгийн үндэс, хөрөнгө оруулалтын хэлбэрийг тодорхойлж, хотын эдийн засаг, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төр, орон нутгаас үзүүлэх дэмжлэг туслалцаа, хотын төсөв, татвар, өмч, үнэт цаас, хотыг хөгжүүлэх сантай холбоотой үүсэх харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

Хархорум хотын эдийн засгийн үндэс нь улс, орон нутаг, хотын өөрийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн хотын өмч, татварын болон татварын бус орлого, хотын сангийн хөрөнгө, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусламж бусад орлогоос бүрдэх ба Хархорум хотод хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч тогтворжуулалтын гэрчилгээг олгох нөхцөл журмыг тодорхойлсон.

Хот нь өөрийн өмчтэй байх ба хотын эдэлбэр газар доорх инженерийн байгууламж, хонгилын систем нь хотын өмчлөлд байна.

Хот нь хот хөгжүүлэх сантай байх ба сангийн эх үүсвэр, зориулалтыг тодорхойлж, тус сангаас зээл олгох, өр авлага үүсгэх, хуульд зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

7 дугаар бүлэгт, Хархорум хотын бүтээн байгуулалтад үзүүлэх дэмжлэг, хөрөнгө оруулалтын талаар тусгалаа.

Хотын бүтээн байгуулалтыг улс, хотын төсөв, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт, зээл, хандив тусламж, сангийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэл болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх ба хөрөнгө оруулалтын хэлбэр, түүний тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, тогтворжуулалтын гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, цуцлах нөхцөлийг татварын болон болон татварын бус дэмжлэг, хэлбэр, хэмжээ хязгаарыг тогтоолоо.

8 дугаар бүлэгт, хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах хотын бэлгэдэл, шагнал, оршин суугчийн эрх, үүрэг болон хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, шилжилтийн үеийн зохицуулалт, хууль хүчин төгөлдөр болох талаар тусгалаа.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар хүлээгдэж байгаа үр дүнгийн тухай сонордуулъя.

Хархорум хотыг богино хугацаанд үр дүнтэй, чанартай зохион байгуулах, үндэсний өв соёлоо хадгалж хамгаалах, олон улсын анхаарлыг татаж, аялал жуулчлал хөгжих, эдийн засгийн интеграцад орж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой улсын зэрэглэлтэй хотыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын үйл ажиллагааны журам зохицуулалт тодорхой болно.

Шинээр ажлын байр бий болж, дотоодын нийт бүтээгдэхүүн гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Иргэдийн аятай таатай амьдрах орчин бий болж амьдралын чанар сайжрах юм. Хот дүрэмтэй болж хууль тогтоомжоор зохицуулагдаагүй хотын амьдрал үйл ажиллагаатай холбоотой асуудлаа оршин суугчид, иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх боломжтой болно.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тусгайлан гаргасан хэлэлцүүлгийн шатад гаргасан санал байгаагүй болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулсан Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр даргад баярлалаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.1-д заасан Тамгын газар энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан болон олон улсын гэрээ соёрхон батлахаас бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн

найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахын өмнө дараах асуудлаар хууль зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана гэж заасантай холбогдуулаад хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд дарга Ч.Ариунхур танилцуулна.

1 номерын микрофоныг өгье.

Ч.Ариунхур: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг танилцуулж байна.

2024 оны 12 сарын 23-ны өдөр. 2024/05 дугаартай.

Хууль зүйн дүгнэлт гаргах үндэслэл.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.1 дэх хэсгийг тус тус үндэслэн энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргалаа.

Хууль зүйн дүгнэлтийн хүрээ хязгаар.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийн талаарх хууль зүйн дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-ээс 1.6-д заасан асуудлын хүрээнд гаргав.

Нэг.Хуулийн төсөл нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль бусад хуульд нийцсэн эсэх, хуулийн төслийн тодорхой зүйл, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх, тухайн төсөл, түүний зарим зүйл, хэсэг, заалтын зохицуулалтыг хэрэгжих боломж харилцан уялдааны талаар:

1.Монгол Улсын Их Хурлаас Орхоны хөндий түүний орчмын талаар газар нутгийг байгалийн цогцолборт газрын ангилалд хамруулан 2006 оны 26 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авч, хилийн заагийг баталсан байх тул Хархорум хотын хилийн зааг, бүсчлэлийг тогтоохдоо түүнийг харгалзан үзэх, түүнчлэн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор төслийн 2 дугаар зүйлд Соёлын өвийг хамгаалах тухай болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиудыг нэмэх нь зүйтэй байна.

2.Хууль тогтоомжийн хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.4-д хуулийн төсөл нь агуулгыг товч тодорхой илэрхийлсэн нэртэй байх, 29 дүгээр зүйлийн 29.1.2-т тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг төсөлд бүрэн тусгах шаардлага тавигддаг.

Хуулийн төслийн гарчигийг Хархорин нутгийн бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай гэж нэрлэсэн боловч төсөлд хотыг бүтээн байгуулахтай холбоотой харилцаанаас гадна эрх зүйн байдлыг нь тодорхойлсон, түүнтэй холбогдох харилцааг зохиц үзүүлсэн байна.

Түүнчлэн төслийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангаж, түүх, соёлын өвийг сэргээх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, байгаль орчинд нээлттэй, ногоон ухаалаг Хархорум хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлсон ч төсөлд түүх, соёлын өвийг сэргээх, тогтвортой аялал, жуулчдыг хөгжүүлэх асуудлыг иж бүрэн тусгаагүй байна.

Иймд, хуулиар зохицуулах харилцааг тодорхой болгож, түүнтэй холбогдуулан төслийн нэрийг оновчлох нь зүйтэй байна.

3.Хуулийн төслийн 1.1, 4.1.1, 4.1.5, 8.1.17, 8.2, 11 дүгээр зүйлд ухаалаг хот, ухаалаг дэд бүтэц, ухаалаг систем, ухаалаг шийдэл гэж, 4.1.4-т олон төрөлт аялал жуулчлал, 4.1.6-д олон төвт хотын тогтолцоо, 12.1.11-д хотын хүний нөөцийн бодлого зэрэг нэр томъёог тусгасан бодлого зэрэг нэр томъёог тусгасан байх бөгөөд эдгээрийг ямар агуулгаар хэрэглэж байгааг ойлгомжтой томъёолох, Хууль тогтоомжийн хуулийн 30 дугаар зүйлийн 34 дэх хэсэгт заасны дагуу нэр томъёог тодорхойлох, эсвэл тухайн заалт бүрд агуулгаар нь дэлгэрүүлж томъёолох хууль хэрэглээг нэг мөр болгоно гэж үзэж байна.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан.

Хуулийн төслийн 3.2 дахь хэсэгт энэ хуульд өөрөөр заагаагүй бол бусад хуульд заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүргийг хотын удирдлага нэгэн адил хэрэгжүүлнэ гэжээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2.3 дахь хэсэгт хот, тосгоны өөрийн удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлж хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна гэж заасан ба мөн хуулийн 68 дугаар зүйлийн зохицуулалтын хүрээнд 69.1 дэх хэсэгт заасан тодорхой чиг үүргүүдийг хотод шилжүүлэхээр заасан.

Гэтэл төслийн 3.2 дахь хэсэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиас давсан илүү өргөн хүрээний зохицуулалтыг хийсэн байх тул уг заалтыг хасах саналтай байна.

5.Төслийн 5.3 дахь хэсэгт эрх зүйн харилцаанд хотыг хотын захирагч төлөөлнө гэснийг хот нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд болохын хувьд ямар төрлийн харилцаанд орох, захирагч хотыг төлөөлөх эрхтэй болохыг тодорхой болгох хэрэгтэй.

Тодруулбал, Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар засаг захиргааны нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ чиг үүргийнхээ дагуу эрх зүйн харилцаанд оролцдог тул тухайн засаг захиргааны нэгж доторх хотын удирдлагын эрх хэмжээг тодорхойлохдоо түүний харьцангуй бие даасан байдлыг хангахын зэрэгцээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяалах нэгжийн удирдлагын эрх, үүргийн зааг ялгааг гаргаж, нарийн тогтоох шаардлагатай байна.

6.Төслийн 6.1-д хотын эдэлбэр газрын хэмжээг тогтоох, түүнийг өөрчлөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр тусгажээ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын тухай хуулийн 12.1 дэх хэсэгт хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын хэмжээ заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж тогтоохоор заасан.

Харин 2024 оны 6 сарын 05-ны өдөр баталсан 2025 оны 6 сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2 дахь хэсэгт хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, өөрчлөх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батлахаар, уг хуулийг дагалдан баталсан Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөн найруулсан, 12.3 дахь хэсэгт нийслэл хот, хот, тосгон, бусад суурин газар нь эдэлбэр газартай байх ба хуульд өөрөөр заагаагүй бол түүний хэмжээ, байршил, заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно гэж тус тус заасан тул хэрэв 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдаж, хүчин төгөлдөр дагаж мөрдөх тохиолдолд Газрын тухай хуулийн 12.1 дэх хэсэгтэй зөрчилдөх нөхцөл үүсэхээр байна.

Түүнчлэн 10.2 дахь хэсэгт хотын газрыг эзэмших, ашиглах эрхийг хотын захирагч олгохоор тусгасан нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 30.1.20 дахь заалттай нийцэж байх боловч хотын захирагч газар эзэмших, ашиглах эрх талаарх зохицуулалтыг газартай холбоотой суурь харилцааг зохицуулж буй Газрын тухай хуультай уялдуулан цогц байдлаар шийдэх нь зүйтэй байна.

Түүнээс гадна Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхыг анхаарах хэрэгтэй байна.

7. Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.4-д хот байгуулалтын баримт бичиг гэж нутаг дэвсгэр, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, түүний суурь судалгааг ойлгохоор, 11.1 дэх хэсэгт хот байгуулалтын баримт бичигт хамаарах зүйлүүдийг заасан байх тул төслийн 7.1-д тусгасан хот төлөвлөлтийн баримт бичгийг нэр томъёоных нь хувьд болон түүнд хамаарах баримт бичгийн бүрдлийг хүчин төгөлдөр хуулийн уг заалтад нийцүүлж уялдуулах нь зүйтэй.

8. Төслийн 8 дугаар зүйлд хот төлөвлөлтөд тавих шаардлагыг тодорхойлж, 34 дүгээр зүйлд хууль зөрчигчид Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгасан.

Гэтэл Зөрчлийн тухай хуульд зөрчлийг хэлбэрээр бус хуулийн нэрийг эшилж, тухайлбал 12.5 дугаар зүйлд Хот байгуулалтын тухай хуульд заасан нөхцөлүүдийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг заасан байна.

Иймд төсөлд тусгагдсан хот төлөвлөлтөд тавьсан шаардлагуудыг биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд нэмж тусгах шаардлагатай байна.

9. Төслийн 9.2 дахь хэсэгт хотын бүсүүдэд явуулах үйл ажиллагааг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр нарийвчлан тогтоохоор тусгасан нь Газрын тухай хуулийн 12.4 дэх хэсэгт бүсчлэлд тавигдах шаардлагыг хот, тосгон бусад суурины эдэлбэр газарт дүрмээр зохицуулах бөгөөд бүсчлэлийн дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална гэж заасантай нийцэхгүй байна.

Бүсэд явуулах үйл ажиллагаа нь бүсийн дүрмээр тодорхойлогдох тул Газрын тухай хуулийн хүрээнд хууль хоорондын нийцлийг хангах нь зүйтэй байна.

Мөн хуулийн төслийн 9.1 дэх хэсэгт хотын эдэлбэр газар нь 14 бүсэд хуваагдахаар буюу бүсүүдийг тухайлан нэрлэж заасан хэдий ч 9.3 дахь хэсэгт хуульд заагаагүй бүсчлэлийг Засгийн газар шинээр тогтоож болохоор тусгасан байна.

Иймд бүсчлэлийг хуулиар нэрлэн тогтоох шаардлагатай тохиолдолд Засгийн газар дээрх олгосон заалтыг хасахыг санал болгож байна.

10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт энэ хууль нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшилд хамтран хэрэгжүүлэх түншлэлийн төслийг төлөвлөх, боловсруулах, үнэлэх, судлан шинжлэлийн үндсэн дээр төслийг

сонгох, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээ байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаанд үйлчилнэ гэж заасан.

Хуулийн төслийн 4 дүгээр бүлгээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг зохицуулахдаа тус бүлгийн 18.1 дэх хэсэгт Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл санаачлах, хэрэгжүүлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна гэж.

Мөн хуулийн 18.2 дахь хэсэгт 18.2.1-ээс 2.18.2.16-д заасан хотын чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болохоор тусгажээ.

Тухайн салбарын харилцааг зохицуулж байгаа суурь хуулиар зохицуулсан харилцааг тус хуулиас гадуур бусад хуулиар өөрөөр зохицуулах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулах эрсдэлтэй тул хотын тодорхой чиг үүргийг бусад этгээдээр гүйцэтгүүлэхтэй холбоотой төслийн 18.2 дахь хэсгийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан журмын хүрээнд хэрэгжүүлэх асуудлыг хоёрдмол утгагүйгээр тодорхойлж, хуулийн заалтыг ашиглож, хууль хоорондын нийцлийг хангах нь зүйтэй байна.

11.Төслийн 24.1 дэх хэсэгт хот нь Зөвлөлийн шийдвэрээр Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн үнэт цаас гаргаж болно гэжээ.

Энэ нь Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.8-д аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал үнэт цаас гаргах чиг үүргээ шилжүүлсэн тохиолдолд хотын захирагчийн өргөн мэдүүлснээр хуульд заасан үндэслэл журмын дагуу үнэт цаас гаргах, зээл авах, зөвшөөрөл олгох гэж Зөвлөлийн бүрэн эрхийг тодорхойлсныг болон Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлд заасан аймаг, нийслэл үнэт цаас гаргах тухай зохицуулалттай зөрчилдөхөөр байна.

Иймд төслийн 24.1 дэх хэсгийг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.8 дахь заалттай нийцүүлэх саналтай.

12.Төслийн 25 дугаар зүйлд хот хөгжүүлэх сантай холбогдсон харилцааг зохицуулжээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлд Хотын дэд бүтцийн сан, 42 дугаар зүйлд Ногоон хөгжлийн сан улсын зэрэглэлтэй хотод байгааг анхаарч төсөлд заасан сангийн нэрийг нийцүүлэх, тус сангийн засаглал, хяналт, хариуцлагын асуудлыг төсөлд тодорхой тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн 25.1.4-т чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлогын 5 хүртэл хувь нь сангийн орлогын эх үүсвэр байхаар заажээ. Үүнтэй холбогдуулан хууль хэрэглээний явцад хийдэл үүсэх эрсдэлтэй

тул орлого тооцох харилцааг холбогдох татварын хуулиудад нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн төслийн 25.1.4-д зааснаар эдийн засгийн тусгай бүсийн асуудал хөндөгдөж байгаа тул тус бүстэй холбогдсон зохицуулалтыг төсөлд нэмж тусгах шаардлагатай байна.

13.Төслийн 28 дугаар зүйлд тогтворжуулалтын гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, цуцлах харилцааг зохицуулжээ.

Төслийн 28.1-д Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-д заасан шалгуурыг хангасан тохиолдолд хөрөнгө оруулагчийн бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн хотын захирагч доор дурдсан хугацаагаар тогтворжуулалтын гэрчилгээ олгоно гээд хөрөнгө оруулалт, хэмжээ, тогтворжуулах болон хөрөнгө оруулалт хийж дуусах хугацааг хүснэгтээр заасан.

Уг хэсэгт хөрөнгө оруулалт хийж байгаа салбарыг тодорхойлоогүй. Түүнчлэн хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, хөрөнгө оруулалтын хэлбэрийг Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаас өөрөөр зохицуулсан байгаа нь тус хуулийн 13.1 дэх хэсэгт энэ хуулийн 4.7-д зааснаас бусад тохиолдолд татварын хувь хэмжээг тогтворжуулах асуудлыг зөвхөн энэ хууль болон энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулна гэсэнтэй нийцэхгүй байна.

Хархорум хотод хөрөнгө оруулалт хийх харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаас өөрөөр зохицуулах шаардлагатай бол зөвхөн тухайн хуульдаа тус зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.

14.Хотын зөвлөлийн гишүүдийг сонгох, зөвлөлийн хуралдаан, шийдвэр, захирагчийг сонгох бүрэн эрхийн хугацаа зэрэг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулсан асуудлыг, мөн төслийн 14.1.4, 12.1.4, 12.1.7, 12.1.12 дахь заалтад тусгасан Хот, тосгоны эрх зүйн байдлын хуультай давхацсан заалтуудыг Хууль тогтоомжийн хуулийн 32 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн тухайн хуулиас тодорхой эшлэл хийж уялдуулах шаардлагатай.

Хоёр.Хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд нь Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн зохицуулалттай уялдсан эсэх, нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хууль, тогтоолын төсөл нь тухайн хууль, тогтоолын зохицуулалтын зорилго, үндсэн зарчимтай нийцсэн эсэх асуудлаар.

2.1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Тус хуулийн төслөөр Хархорум хотын зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх шийдвэр гаргахаар заасан бөгөөд Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих

тухай хуулийн төслийн 15 дугаар зүйлд хотын зөвлөл, түүний бүрэн эрхийг тодорхойлохдоо ийнхүү санал гаргах бүрэн эрхийг тодорхойлоогүй байгааг анхаарч хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд хотын зөвлөл энэ асуудлаар санал гаргах бүрэн эрх мөн олгогдоогүй байна.

2.2.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т “хотын зөвлөл захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг дарга” гэснийг “Хархорум хотын Бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуульд зааснаар” гэж тус тус өөрчлөхөөр тусгасныг Үндсэн хууль дахь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын үндсэн зарчимтай уялдуулах шаардлагатай.

Тодруулбал, хотын зөвлөлийн чиг үүргийг хуулийн төслийн 35.3-д заасан түр зөвлөл хэрэгжүүлэх нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүргийг ард түмнээс сонгогдоогүй түр мандатын этгээд хэрэгжүүлэхээрээ зохицуулсныг дахин нягтлах.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хот, тосгон нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж биш бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон буюу оршин байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид засаг захиргааны хувьд харьяалагдах тул зохих шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, өөрийн бүрэн эрхийн хүрээнд хот, тосгоны удирдлагатай хэрхэн харилцахыг тодорхойлох. Цаашид Хархорум хот нь Өвөрхангай аймгийн Хархорин сумаас гадна Архангай аймгийн Өгий нуур сум, Хашаат сумын нутаг дэвсгэрийг дамнан байршиж хөгжих тохиолдолд энэ тухай засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог өргөн мэдүүлсэн төсөл тодорхой болох нь зөв юм.

2.3.“Хархорум хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

Тогтоолын төслийн 4 дэх заалтаар Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай 07 дугаар тогтоолын гарчигийг, мөн тогтоолын 1, 2 дахь заалтыг өөрчлөхөөр.

Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн Хот байгуулах тухай 72 дугаар тогтоолын 1 дэх заалтыг өөрчлөхөөр тусгасан нь хууль зүйн

техникийн хувьд тухайн тогтоолоор зохицуулах харилцааны агуулгаас хальсан шинжтэй байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоол нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон уг тогтоолын төсөл батлагдаж, хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх тохиолдолд хот байгуулах эрх зүйн үндсийг тогтоосон анхдагч тогтоолын үйлчлэлтэй зөрчилдөж болзошгүйг анхаарах шаардлагатай.

Дүгнэлт.

Саналын хэсэг.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын зэрэглэлтэй хотын өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар тогтоосон.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нь органик шинжтэй суурь хууль болохын хувьд тус хуулийн 3.1 дэх хэсэгт нийслэл Улаанбаатар хот, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгонтой холбоотой тухайлан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна гэсний дагуу Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл нь тус хуулиар тогтоосон зарчим зохицуулалттай нийцэх ёстой буюу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулагдсан суурь харилцааны агуулгад нийцэж байх ёстой.

Хуулийн төслийн бүтэц, зохицуулж буй харилцааны агуулгыг авч үзвэл хуулийн төслийн зорилтод заасан харилцааг бүрэн зохицуулаагүй. Тухайн хуулиар зохицуулах харилцаанд хамааралгүй суурь хуулиудаар зохицуулсан харилцааг өөрөөр зохицуулсныг хэлэлцүүлгийн шатад анхаарч, төслийг боловсронгуй болгох шаардлагатай.

Мөн хуулийн төсөл нь Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай гэсэн нэртэй хэдий ч төслөөр хотын эрх зүйн байдлыг давхар зохицуулсныг анхаарах хэрэгтэй байна.

2.Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Үндсэн хуулийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх зүйн үндсийг тодорхойлсон 4 дүгээр бүлгийн зохицуулалттай нийцүүлэх, зохих шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага өөрийн бүрэн эрхийн хүрээнд тухайн засаг захиргааны нэгж дэх хотын удирдлагатай хэрхэн харилцах асуудлыг тодорхой болгох нь зүйтэй байна.

3.Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг батлах тохиолдолд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиас гадна Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот байгуулалтын тухай, Газрын тухай, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай зэрэг тухайн салбарын суурь хуулиудын холбогдох зохицуулалттай нийцүүлж, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах шаардлагатай.

4.Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх шатад нэр томьёо, хууль зүйн техникийн шаардлагыг хангуулах нь зүйтэй байна.

Дүгнэлт дууслаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Хууль зүйн дүгнэлт танилцуулсан Ч.Ариунхур даргад баярлалаа.

Одоо хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү?

С.Зулпхар гишүүнээр тасаллаа. С.Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Тэгэхээр их онцлогтой хууль орж ирж байна. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах хүрээнд олон жил яригдаж ирсэн.

Тэгээд хангайн бүс буюу төвийн бүсдээ нэг томоохон хот сууринтай болчихъё гэсэн санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч гаргаад, Засгийн газарт чиглэл өгөөд, үүний дагуу Засгийн газраас хуулийн төслийг өргөн мэдүүлж байгаа.

1220 онд анх Хархорум хот, Монгол Улсын нийслэл байгуулагдаж байсан түүхтэй.

2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж эртний нийслэл Хархорум хот, шинэ хот, суурин байгуулах зарлиг гаргаж байсан. Энэ хүрээнд орж ирж байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр 2019 онд бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 57.2-т Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай асуудлыг Засгийн газар санаачилж Их Хурлаар батлуулна гэж тусгасан. Одоо энэ заалт амилж байна.

Хоёрдугаарт нь, бас анхдагч хуулийн төсөл өргөн мэдүүлж байгаа. Үүнтэй холбоотой хууль зүйн дүгнэлт сая сонсож байна.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаас яг энэ дээр та ямар байр суурьтай байна вэ? Бид бүхэн энэ хуулийг батлахад, хуулийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллаж байсан хүний хувьд.

Мөн цаашдаа орж ирсэн хуулийн төслийг сая хууль зүйн дүгнэлтээс харж байхад зарим дүгнэлт нь бас нэг жоохон зөрчилтэй байна шүү гэсэн дүгнэлт гарч ирж байна. Үүнийг та хариулж өгөөч.

Цаашдаа бид ер нь зөвхөн одоо юу гэдэг юм улсын чанартай Хархорин хот байгуулах асуудал хөндөгдөж байна. Үүнээс гадна баруун бүсдээ бас улсын чанартай хоттой болох, зүүн бүстэй хоттой болох, өмнөд бүстэй хоттой болох. Ганцхан Улаанбаатар хот гэсэн ганцхан таталцлын төвтэй. Тэр лүүгээ л бүгд тэмүүлдэг, түүндээ шавдаг, түүндээ түгжирдэг, бөглөрдөг биш өөрүүн бүсийнхэн баруун бүс нутагтаа нэг таталцлын төвтэй болъё. Тухайлах юм бол Ховд хот. Бас эртний түүхтэй хот.

Одоо өмнөд бүсийнхэн Өмнөговь аймагт Даланзадгад. Зүүн бүсдээ одоо Дорнодод байх юм уу, эсвэл Хэнтийд байх юм уу. Бас нэг таталцлын төв. Ингэх юм бол Улаанбаатар хотыг бас задлаад олон газруудад шинэ улсын чанартай хотууд байгуулаад тэнд ард иргэдийг ажилтай орлоготой, аятай тухтай амьдрах бололцоо боломжийг бий болгочих юм энэ шийдэгдэхгүй байгаа асуудлыг шийдэхэд нэг дэм болох байх. Энэ тал дээр ямар байр суурьтай байдаг юм бэ? Үүнийг хариулж өгөөч.

Цаашдаа ийм байдлаар улсын чанартай хотууд байгуулаад явах бололцоо боломжууд. Үүнийг манайхан хэр харж байгаа юм бол? Үүнийг ажлын хэсэг хариулж өгөөч.

Ц.Сандаг-Очир: С.Бямбацогт гишүүний асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар. Ажлын хэсгийн 5 дугаар микрофонд хариулна. Г.Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хархорум хотын бүтээн байгуулалтыг дэмжих тухай энэ хуулийн агуулга бол 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч 230 тоот зарлиг гаргаж, Хархорин хотыг сэргээн байгуулах тухай, түүний 1.3 дугаар заалтад Хархорум хот байгуулах эрх зүйн үндсийг тогтоох, мөн Хархорум хотын төлөвлөлт, бодлоготой нийцүүлсэн энэ эрх зүйн орчныг бүрдүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон.

Үүний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас “Хархорум хотыг сэргээн байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдаж бас энэ эрх зүйн үндсийг тогтоох шийдлүүд гарсан.

Үүний дагуу ингээд энэ хууль өргөн барьж байгаа. Тэгэхдээ Үндсэн хуулийн 57.1, 2 дугаар зүйлүүдэд зааснаар орон нутгийн болон улсын чанартай хот байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасан.

Тэгэхээр тусдаа хууль байж болно гэсэн агуулга энд байгаа юм. Өөрийн удирдлага, зохион байгуулалтыг хуулиар тогтооно гэж.

Хоёрдугаарт нь, засаг, захиргааны нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан учраас хууль санаачлах эрх, хязгаарын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс чиглэл өгсөн зарлигийн дагуу Засгийн газраас өргөн мэдүүлж хэлэлцүүлж байна.

Энэ эрх зүйн дүгнэлттэй холбогдуулж мэдээж хууль хоорондын нийцэл, зөрчлийг Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүй, дүн шинжилгээний хэлтэс дүгнэлт гаргасан байна.

Тэгэхдээ агуулгын хувьд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг бүрэн ойлгоогүй, хууль тогтоогчдын хууль санаачлах эрх, хүрээ хэмжээ хязгаарт халдсан шинж чанартай зарим дүгнэлтүүд байгаа нь манай улсын туршлагатай холбоотой л доо. Хууль тогтоох ажлын хүрээнд ч гэсэн тэр сүүлийн 30 жилд бид ямар ч хот байгуулаагүй.

Монгол Улсын хэмжээнд шинээр хот байгуулаагүй учраас Улаанбаатар хотод сүүлийн 20 жилд албан ёсны бүртгэлтэйгээр шилжиж ирсэн 594 мянган хүн шилжиж ирээд ингээд Улаанбаатартай шавааралдаад, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдол, бүх нөхцөл юм чинь стандарт бус болчихсон учраас Ерөнхий сайд ч гэсэн өчигдөр сонинд мэдээлэл өгөхдөө тусгай эрх зүйн орчин бүрдүүлж байж л энэ асуудлыг шийднэ.

Асуудал өөрөө стандарт бус учраас тусгай эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагын үндсэн дээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль ч гэсэн нэлээн дуншиж дуншиж батлагдсан бүрэн гарсан хууль биш. Жишээлбэл, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай уялдуулах хэрэгтэй гэж байгаа тэр заалт бол хотын зөвлөлийн эрх хэмжээ, чиг үүргийг тогтоогоогүй. Ямар бүрэлдэхүүнтэй байх нь тогтоогдоогүй.

Ийм учраас энэ хууль нь давхардсан ч гэсэн тодруулж зааж байгаа юм. Өөрөөр хэлбэл нэг удаагийн шинжтэй хууль баталчих. Улаанбаатар хотын түгжрэлийг сааруулах тухай хууль хүртэл баталж байсан шүү дээ. Нэг удаагийн шинжтэй.

Тэгэхээр Хот байгуулалтыг дэмжих тухай хууль бол Үндсэн хуулийн энэ агуулга үзэл санаатай нийцүүлж шинээр байгуулж байгаа. Улаанбаатар

хотод одоо 500, 600 мянган мянган хүн шилжиж ирээд байх тусам л Улаанбаатарт хэчнээн том бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, зам барилаа ч гэсэн улам л нэмэгдээд л. Улсын үндэсний аюулгүй байдлын хувьд ч гэсэн тэр Улаанбаатар улс болоод захаараа хөдөө орон нутаг маань эзгүйрэх гээд байна.

Хөдөө орон нутгаас хэчнээн зуун мянган хүн жил ингэж шилжин ирсээр байх вэ.

Ийм учраас шинэ төвлөрлийг энэ хангайн бүсэд хуучин эртний 7 нийслэлийг түшиглээд байгуулах нь зүйтэй. Үүний тулд тусгай хууль баталж, түр хууль баталж, түр зохицуулалт хийж энэ эрх зүйн үндсийг тогтоох шаардлагатай.

Тийм учраас энэ бол Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх л дүгнэлт гарна уу гэхээс биш бусад хуультай зохицуулж, нийцүүлж, өөрчилж батлах нь хууль тогтоогчдын бүрэн эрхийн асуудал. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль ч гэсэн одоо мөрдөгдөж эхэлнэ. Шинэ эрх зүйн орчин. /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? С.Бямбацогт гишүүн тодруулъя.

С.Бямбацогт: Тэгэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 57.2 үндсэндээ амилаад одоо хэрэгжих гэж байна.

Сүүлийн 20, 30 жил ерөөсөө, 1992 онд үндсэндээ хотгүй болчихсон шүү дээ. Ганцхан Улаанбаатарын хоттой болчихсон. 21 аймгийн төв сум болчихсон. Одоо буцаагаад улсын чанартай хотууд байгуулагдах ёстой. Улсын чанартай хот анхных нь бие даасан хуультай болж орж ирэх гэж байна л даа.

Тэгээд энэ дээр манай энэ эрх зүйн дүгнэлт, хууль зүйн дүгнэлт өгсөн улсууд маань бас нэг жоохон зөрчилтэй байна гээд яриад байгаа. Үүнийг одоо яаж зөрчлийг арилгах боломж байна вэ? Зөрчил байгаа юм уу, байхгүй юм уу? Засгийн газар өргөн барьсан. Ерөнхийлөгч бас зарлиг гаргасан. Эхнээсээ бид зөв жишиг тогтоож явахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Энэ дээр нэг хариулт өгөөд.

Дахиад дээрээс нь өөр улсын чанартай хотуудыг баруун бүсдээ, зүүн бүсдээ, өмнөд бүсдээ байгуулах боломж байгаа юу, байхгүй юу? Энэ дээр ямар байр суурьтай байдаг юм бол? Ерөнхийлөгчийн Тамгын газраас асууя. Судалгаа хийсэн байх даа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Г.Занданшатар дарга.

Г.Занданшатар: Цаг хязгаартай учраас товч хариулъя.

Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бүр 2002 онд батлахдаа бүсийн тулгуур төвүүд Ховд хот, зүүн бүсийн төв, баруун бүсийн төв, Хангайн бүсийн төвүүдийг хот болгон хөгжүүлэх тийм Улсын Их Хурлын тогтоол 2002 оноос хойш батлагдсан.

Энэ Орхоны хөндийд шинэ хот байгуулах тухай асуудал бүх намын мөрийн хөтөлбөрт ч тэр, бүх үе үеийн Улсын Их Хурал тогтоол гаргаж Орхоны хөндийд шинэ хот байгуулна гэж баталж байсан.

Одоо сүүлийн 5 намын мөрийн хөтөлбөрт, парламентад суудалтай бүх намуудын мөрийн хөтөлбөрт энэ байгаа. Гэвч энэ хэрэгждэггүй. Одоо ингээд л 20 жил Улаанбаатартаа төвлөрөөд л, түгжрээд л байгаа учраас тусгай хууль баталж байж, энэ бүтээн байгуулалтыг дэмжиж байж, татварын болон эрх зүйн онц орчныг нь тусад нь бий болгож байж, тусгай орчин бүрдүүлж байж л энэ хот байгуулагдаж байж стратегийн шийдэл нь Улаанбаатарын төвлөрөл, түгжрэл арилах. Цаашлаад үндэсний аюулгүй байдлын асуудал учраас. Одоо хүрээ хязгаар нутаг маань эзгүйрэх гээд байна. Улаанбаатартаа бүгдээрээ шавааралдаад.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулчихъя. 5 номерын микрофоныг нэмж өгье.

Г.Занданшатар: Тийм. Ховд хотыг бүсийн тулгуур төв хот болгож хөгжүүлнэ гэсэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал Бүсчилсэн хөгжлийн тухай хуулиар бүр 2020 онд баталчихсан.

Ховд хотыг баруун бүсийн тулгуур төв болгочихсон. Одоо бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал шинэчлэгдсэн учраас одоо энэ 5, 6 бүсэд хуваагдаад сонгууль хүртэл ингэж явж байгаа учраас үүнтэйгээ нийцүүлээд энэ бүсчилсэн хөгжлийн бодлогоо илүү тодорхой болгох, шинэ төвлөрлийн бүсүүдийг зөвхөн Хархорум шинэ хот байгуулах төдийгүй бүсийн тулгуур төв хотуудаа ч гэсэн энэ хот байгуулалтын жишгээр шинэчлэх шаардлага байгаа юм.

Тэгээд бидэнд хот байгуулалтын туршлага байхгүй. Нүүдэлчдийн соёл иргэншил, социализмын хот байгуулалт, төлөвлөлт, өнөөдрийн Улаанбаатарын өнөөдрийн байдал нөхцөл маань одоо энд шинэ тусгай орчин бүрдүүлж байж л, зарим талаар стандартын бус шийдэл ч гэсэн хийж байж энэ шинэ хотоо байгуулах, Улаанбаатарын төвлөрөл, түгжрэлийг сааруулах, цаашлаад 594 мянга.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: С.Бямбацогт гишүүн тодруулъя.

С.Бямбацогт: Их Хурлын Тамгын газраас тодруулчихъя. Энэ хууль зүйн дүгнэлт гаргахдаа бас нэлээн хуулиуд хооронд зөрчилтэй байна гэсэн байна л даа.

Тэгэхээр энэ дээр би бас нэмж асуух гээд байгаа юм. “Алсын хараа-2050”-ийг бид 2020 онд баталсан. “Алсын хараа-2050” чинь бол урт хугацааны хөгжлийн бодлого. Урт хугацааны хөгжлийн бодлогодоо тулгуурлаад дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр буюу одоо бид 8 зорилтот хөтөлбөрийг 10 жилийн хугацаатай батлах ёстой.

8-аас ганцхан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нь батлагдчихсан явж байгаа. 8-аас ганцхан нь.

Энэ яг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал урт хугацааныхад нь яаж туссан байна, дунд хугацааныхад нь яаж туссан байна. Яг үүнтэй одоо энэ орж ирж байгаа хуулийн төсөл маань нийцэж үү, нийцээгүй байна уу? Үүнийг хариулж өгөөч.

Түүнээс гадна сая ярилаа. Баруун бүсдээ нэг талцлын төвтэй болмоор байна гэж. Тухайлах юм бол одоо Ховд. Энэ бас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суусан байх ёстой. Энэ суусан байна уу, суугаагүй байна уу? Суухдаа яаж суусан байна. Манай Их Хурлын Тамгын газрынхан хариулаад өгөхгүй юу?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 1 номерын микрофон. Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргасан.

Ч.Ариунхур: Ч.Ариунхур. С.Бямбацогт гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, өмнө нь С.Бямбацогт гишүүний асуусанчлан Тамгын газрын Хуулийн газраас гаргасан хууль зүйн дүгнэлт дээр тодорхой хотыг хуулиар байгуулахтай холбоотой асуудал нь боломжгүй гэдэг дүгнэлт гараагүй.

Яг хуулийн агуулгын хувьд доторх зүйл, заалт нь зарим хуульдаа, эсвэл хоорондоо Улсын Их Хурлаас баталсан зарим тогтоолын заалтын үйлчлэх хугацаа зэрэгтэй зөрчилдөж байгаа, зөрчилдөж болзошгүй байгаа талаар дүгнэлт гаргасан байгаа.

Үндсэн хуулийн заалт хөндөгдсөн 58 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг энэ дүгнэлтэд хөндөгдсөн үндэслэл нь болохоор Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хот, тосгон, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан. Хуулийн төслийн 3.2 дахь хэсэгт болохоор.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Микрофоныг нэмж өгье. Ажлын хэсгийн 1 номерын микрофон.

Ч.Ариунхур: Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуульд заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүргийг хотын

удирдлага нэгэн адил хэрэгжүүлнэ гэсэн 3.2 дахь хэсгийн заалт төсөлд тусчихсан байгаа юм.

Тэгэхээр зарим чиг үүргийг шилжүүлнэ гэдэгтэй энэ заалт хэрхэн, бас уялдуулах шаардлагатай байх гэж үзэж байгаа юм.

“Алсын хараа-2050”, Бүсчилсэн хөгжлийн бодлого.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсэг 1 номерын микрофоныг нэмж тайлбар өгье гэж байна.

Ч.Дондогмаа: С.Бямбацогт гишүүний асуултад тодруулж хариулья.

Улсын Их Хурлаас 2014 онд батлагдсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал байгаа.

Бүсчилсэн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд Монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, дэлхийн нүүдэлчин, соёлын, голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрт тулгуурлан, уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн бүс болон хот байгуулалтын дэд бүс болно гэж хангайн бүсийн зорилгыг тодорхойлсон.

Энэ зорилгын хүрээнд Орхоны хөндийд нийслэлийн баримжаатай “Шинэ Хархорум” хотыг байгуулж засаглалын төвлөрийг зохицуулна гэсэн арга хэмжээ тусгагдсан.

Ийм учраас “Шинэ Хархорум” хотын хуулийнх нь агуулга. Энэ бол бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцэж байгаа гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Одоо С.Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Хуралдаан даргалагч, Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. 3 асуулт байна.

Эхнийх нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар даргаас нэг асуулт байгаа юм.

Та сая хэллээ. 2002 оноос хойш Ерөнхийлөгчийн төрийн тодорхой институцийн хүрээнд гарч байсан санаачилга өнөөдөр явсаар байгаад хууль болж байна гээд. Бид талархалтай байна. Үнэхээр энэ хууль болох ёстой. Энэ хот ч гэсэн ахиж шинээр том хот болж байгуулагдах ёстой гэдэгтэй санал нэг байгаа юм.

Үүнтэй холбоотой нэг асуулт. Одоо энэ хуулийн зорилт дээр байгаа юм л даа. Түүх, соёлын өвийг сэргээхэд чиглэсэн бүсчилсэн хөгжилтэй уялдсан байдлаар энэ хотыг байгуулах юм гэж.

Монголчуудын төрт усны түүх бол 2200 гаруй жилийн түүхтэй. Тухайн бүс, газар нутагт 7 төрт улс байгуулагдсан. 7 төрт улсын нийслэл нь тухайн бүс нутагт байсан байгаа юм.

Тэгэхээр нь яг энэ асуудлыг төрт улсын түүхийн нийцэл онцлог талаас нь бас авч үзсэн үү? Энэ асуудлыг харгалзаж байгаа юу гэдэг нэг ийм ийм асуулт байгаа юм.

Хоёр дахь асуулт бол Н.Нацагдорж даргаас асууж байгаа юм. Би энэ хуулийн зорилтыг уншлаа. Түүнээс гадна зарчим байж байгаа. Хотоо яаж байгуулахтай холбоотой зарчмуудыг их тодорхой тусгасан байна л даа. Энэ дээр бид ухаалаг хотыг байгуулна гэж байна. Түүх, соёлыг дээдчилсэн хот байгуулна гэж байна. Тогтвортой аялал жуулчлалыг анхаарна гэсэн байгаа юм.

Тэгэхээр Хархорум хот өөрөө архитектурын өвөрмөц шийдэлтэй ийм хот байсан гэж бид түүхэн талаас нь ойлгодог. Тэгж бид мэдэж байгаа учраас.

Тэгэхээр энэ зарчмууд дээр, хот байгуулахтай холбоотой асуудал дээр архитектурын шийдлийг түүхэн болон магадгүй монгол архитектурын гэдэг ч юм уу, өнөө цагийн архитектуртай уялдсан байдлаар яаж шийдэх вэ гэдэг ийм зохицуулалт орж ирж байгаа юу гэдэг нэг ийм асуулт байна.

Гурав дахь асуултыг би Б.Батцэцэг дарга хариулах болов уу гэж бодож байна. Энэ зөвлөлтэй холбоотой нэг зүйл байна. Зөвлөл бидний ойлгосноор Хотын эрх зүйн байдлын тухай хуулиар энэ зөвлөл 11 гишүүнтэй байхаар байгаа юм.

Тэгэхээр одоо энэ хуулиар 21 гишүүнтэй байгаад, 9 гишүүнийг нь тодорхой институцийн төлөөллөөс шууд томилоод, бусдыг нь иргэдийн дундаар сонгоно гэсэн ийм онцлогтой байгаа юм.

Тэгэхээр үүнийг одоо яаж бодож хийсэн бэ гэдэг нэг ийм асуулт байна. Үүнтэй уялдсан байдлаар бид сая нэгэнтээ энэ түүхэн хоттой уялдсан байдлаар энэ зөвлөл ер нь түүхчдийн гэдэг юм уу, соёл судлаачдын ч юм уу ийм төлөөлөл байх уу? Тэгж байж энэ хотыг бид байгуулах чиглэлээр онцгойлон анхаарах ийм чиглэлийг Та бүхэн тусгаж анхаарч байгаа юу гэдэг ийм асуулт байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн. Н.Учрал сайд тайлбар өгөх үү? Н.Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль дээр Их Хурлын Тамгын газраас ийм хууль зүйн дүгнэлт өгсөн байна л даа.

Ер нь Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг бид өмнөх парламентаар баталсан. Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар улсын зэрэглэлтэй хот, орон нутгийн зэрэглэлтэй хот гээд ийм хоёр статус бий болж байгаа.

Дээрээс нь Хот, тосгоны эрх зүйн байдлын хуульд шилжилтийн үеийн зохицуулалттай. Жишээ нь, аймаг, орон нутагт нутгийн өөрөө удирдах байгууллагыг иргэд сонгодог. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол энэ шилжилтийн үеийн зохицуулалтаараа одоо орон нутгийн зэрэглэлтэй хот дээр ч бай, улсын зэрэглэлтэй хот дээр ч бай зөвлөл болох ёстой. Тэгээд нэг зөвлөлийн гишүүд болж байгаа гэсэн үг. Нөгөө иргэдийн хурлууд. Тэгээд хуулиар хотын захирагчийг иргэд өөрөө сонгодог ийм эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Ингээд улсын зэрэглэлтэй хот нь яг ямар хотууд байх юм. Жишээ нь, нийслэл Улаанбаатар хот дээр Багануур, Налайх хоёр жишээ нь улсын зэрэглэлтэй хот болно. Бусад нь жишээ нь, хот, хороолол гээд ийм нэгжүүд бий болж байгаа шүү дээ.

Тэгэхээр нөгөө 15 хоттой, 50 хэдэн нэгжтэй ч гэдэг юм уу. Ингээд зохион байгуулалтад орно.

Тэгэхээр тухайн үед яг энэ асуудал хөндөгдөөд, Г.Занданшатар даргыг Их Хурлын даргаар ажиллаж байхад шүү дээ. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хуулийг баталсан. Үинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хуулийг баталснаараа Шинэ Зуунмод хотод сая Хөшигийн хөндийн захиргаагаа тэр Захирагчийн ажлын алба руу шилжүүлээд Шинэ Зуунмод хот захирагчтай болоод, сая Шинэ Зуунмод хот дээр гаднын хөрөнгө оруулалт татах ийм нөхцөлүүд бүрдэж байгаа байхгүй юу.

Яагаад гэхээр Их Хурлаараа энэ газар, нэгжийг тэр шинэ Зуунмод хотод харьяалагдана гээд нөгөө Их Хурлын онцгой бүрэн эх учраас шийдчихсэн. Тэгээд захирагчтай, статустай, тэгээд одоо үйл ажиллагааны чиглэлтэй, дээрээс нь хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөлттэй болоод эхлэхээр хөрөнгө оруулалт татах, дэд бүтэц дээрээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр дэмжлэг үзүүлэх бололцоонууд бүрдээд эхэлж байгаа юм.

Тэгэхээр Хархорум хотын бүтээн байгуулалтын хөгжлийг дэмжих тухай хууль өөрөө энэ чинь Архангайн сум, Өвөрхангай аймгийн сум. Нэг ёсондоо тэр Орхоны хөндийн тэр газар нутаг дээр шинэ хот байгуулах гэж байгаа учраас энэ бол зүгээр нэг тийм Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн дагуу энэ нэг улсын зэрэглэлтэй хот юм ч гэдэг юм уу нэр өгөөд явчих ямар ч бололцоо байхгүй. Энэ харин бүр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага руу халдсан зохицуулалт болох учраас энэ өөрөө бие даасан хот болж байж, тэгээд тэр яг газар нэгжээ Их Хурлаар шийдэж байж цаашаа урагшилна.

Тийм ч учраас Засгийн газар өөрөө энэ газар, нэгжийнх нь саналыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн асуудал учраас, Засгийн газар өргөн мэдүүлдэг хуультай учраас Засгийн газраас өргөн мэдүүлээд, мэдээж 2022 оны Ерөнхийлөгчийн зарлиг байдаг.

Тэгээд энэ хүрээндээ 3 нам гурвуулаа Хархорум хотыг сэргээн байгуулна, бүтээн байгуулна, дэмжинэ гэхсэн.

Тэгэхээр Засгийн газраас өргөн мэдүүлээд ажлын хэсэгт Ерөнхийлөгчийн Тамгын газар оролцоод бид явж байгаа юм. Тэгэхээр Их Хурал дээр ингээд нэг ийм дүгнэлт гаргачхаад энэ хоорондоо хийдэл зөрчилтэй гээд яривал бүр эхнээс нь ярих болно. Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль, одоо ер нь энэ нэлээдгүй их ажил өрнөх байхгүй юу.

Тэгэхээр үүнийг бас эргэж харахгүй бол бид ингээд гишүүдэд нэг ийм хууль зөрчсөн юм шиг ийм ойлголт өгөөд байх нь би бас зохимжгүй л гэж бодоод байгаа юм.

Тийм учраас ер нь Хархорум хотоо, ер нь дэлхийд үлдсэн нэг цөөхөн монгол брэндийн нэг чинь энэ Каракорум гэдэг нэр байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээрээ захирагчаа томилоод. Энэ чинь Төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах гээд байгаа хот болохоос биш төсвөөс санхүүжүүлээд л нэг ийм хот барих гээд байгаа юм ерөөсөө байхгүй.

Анхнаас нь зөв төлөвлөө, анхнаас нь шаардлагуудаа зөв тавья гэдэг утгаараа л хандаж байгаа шүү.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Г.Занданшатар дарга нэмж хариулъя.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын Тамгын газар бас богино хугацаанд яаруу сандруу дүгнэлт гаргаж байгаа учраас ойлгож байна л даа. Тэгэхдээ нэг зүйлийг тодруулаад хэлчихмээр байна.

Үндсэн хуулийн 57.2 дугаар заалт яагаад орсон бэ гэхээр хот тосгон, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлнэ гэсэн энэ заалт яагаад орсон бэ гэхээр Дархан, Эрдэнэт хоёрынх хот боловч аймгийн. Нэгжийн чиг үүрэг гэдэг чинь аймаг, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг байхгүй юу. Аймаг хэвээрээ үлдэх гээд. Үүнээс болоод Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гацаад байсан учраас үндсэндээ улсын чанартай хот гэж Дархан, Эрдэнэт, Дархан хот, Дархан аймаг, Дархан-Уул аймаг, Орхон-Уул аймаг, Дархан хот, Эрдэнэт хот хоёр чиг үүрэг давхардаж болно гэсэн утгаар энэ заалт орсон юм.

Тийм учраас Үндсэн хуулийн үндсэн агуулгыг нь ойлгохгүй учраас тэр лүү ойртуулаад байна.

Хоёрдугаарт нь, хуулиуд зөрчилдөж болно. Зөрчилдөөд хот байгуулж болохгүй байгаа учраас л үүнийг нэг удаагийн хуулиар зохицуулах гэж нэг удаагийн хууль санаачилж байгаа шүү дээ. Тэгэх юм бол одоо байгуулагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар жишээлбэл зөвлөлд тавигдах шаардлага байхгүй. Энэ зохицуулж болохгүй учраас нэг удаагийн хууль санаачилж тусгай эрх зүйн орчин бүрдүүлж байгуулж байгаа юм. Яг ийм хуулийг маш олон хуультай зөрчилдүүлээд л түгжрэлийг сааруулах хуулийг баталж байсан.

Тийм учраас энэ агуулга, өнцгөөр нь харахгүй бол энэ сүүлийн 20, 30 жил хот байгуулагдаагүй.

Тийм учраас хот байгуулах хуулийг чинь тусгай хууль гаргаж байж батлахгүй бол. Тэр битгий хэл зөвхөн тусад нь зориулаад газрын тосны үйлдвэрт зориулсан хууль ч баталж болно шүү дээ. Энэ нөгөө үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн шаардлага дээр үндэслээд ийм тусгай эрх зүйн орчин бүрдүүлж байгаа гэдгээ ойлгохгүй бол. Манай бүх хууль үндсэндээ зөрчилдөөнүүдийн элементүүд байдаг. Нэр томьёонууд. Тэгээд бүгдийг нь тэр хуультай, энэ хуультай гээд. Одоо Тендерийн хуулиас авхуулаад бүх хуультай энэ хот байгуулагдахгүй юм билээ.

Ийм учраас л нэг удаагийн тусгай хууль баталж байж. Нэг удаагийн гэж онцолж байна шүү. Тийм ээ. Бүтээн байгуулалтыг дэмжих тухай хууль байхгүй юу. Тэгж дэмжиж байж энэ эрх зүйн орчныг бүрдүүлж байж Хархорум хот байгуулагдана. Ийм л агуулгатай хууль гэдгийг бас эхнээс нь.

Үндсэн хуулийн 57.2-т, 58-д орсон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд ч гэсэн үүнтэй уялдана. Бид дандаа социалист маягаар хот байгуулж ирсэн учраас дээрээсээ байгуулчихдаг. Эрдэнэт үйлдвэр байгуулагдаж эдийн засгийн чадавх бий болохоор Эрдэнэт хот байгуулагдаж байгаа юм. Суманд нэгдэл байсан учраас сумын төв, тосгон байгуулагддаг.

Ингэж нөгөө эдийн засагтайгаа уялдаж ингэж байгуулагддаг байсан учраас манайд сүүлийн 30 жилд хот байгуулагдаагүй. Зөвхөн Улаанбаатар хотоо төвлөрөөд түгжрээд, одоо агаар, хөрсний бохирдол ямар хэмжээнд хүрсэн. Энэ бүх шаардлагаар л нэг удаагийн хот байгуулж. Ингэж байж энэ Казахстан, Индонез, олон улсын туршлага ч гэсэн тэр эдийн засаг тэлдэг, хөгждөг, хотын төвлөрөл саардаг, эрүүл, аюулгүй, эко хот байгуулах гээд байна шүү дээ. Энэ бүх шаардлага чинь өөрөө тусгай хууль баталж л энэ эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагыг бий болгож байгаа гэдгийг бас онцолж тэмдэглэж байгаа юм.

Ийм учраас Засгийн газар яаралтай горимоор өргөн мэдүүлж, Ерөнхийлөгч бас санаачилж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр ч гэсэн олон удаа хэлэлцэж энэ асуудал явж байгаа гэдгийг эрхэм гишүүдийг Тамгын газрын дүгнэлтийг харьцуулахдаа бодож үзээсэй гэж хүсэж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? С.Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн дүгнэлттэй холбоотой зүйлийг Та бүхэн тайлбарлаад байх шиг байна.

Миний асуулт бол Г.Занданшатар даргаас өөр асуулт. Тийм ээ. 7 төрт улсын нийслэл байсан газар нутаг шүү дээ. Үүнтэй холбоотойгоор онцгойлон энэ асуудлыг авч үзсэн ийм хуулийн зорилт бол байгаа юу л гэж асууж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Г.Занданшатар: Баярлалаа. Энэ эрх зүйн дүгнэлтээ тойроод мэтгэлцээн өрнөөд байгаа учраас түүн дээр голлон хариулаад цаг дууссан.

Тэгэхээр энэ Хархоринд хот байгуулах асуудлаар Улсын Их Хурлын ажлын хэсэг 2022 онд байгуулагдаж, 2022, 2023 онд яг тэр бүс нутагт ажиллаж Орхоны хөндий дэх эртний археологийн түүх дурсгалын газар Гол мод, Ганц модны Хүннүгийн булшнаас авхуулаад бүх археологийн олдвор, Лууд хот, энэ эртний 7 нийслэлийн туурь газраар явж Улсын Их Хурлын дарга тэргүүтэй ажлын хэсэг тэнд 14 хоног ажиллаж, газар сонгох бүх ажилд оролцож явсан юм.

Тэнд үнэхээр Монголын эртний Хүннүгийн Луут хотоос авхуулаад эртний 7 нийслэлийн туурь балгас бий. Зөвхөн археологи, соёл, түүхийн хувьд энэ өөрөө Монгол Улсын ирээдүйн түүх соёл, аялал жуулчлалын төв гал голомт болж хөгжих, төвлөрлийг сааруулах маш том хөгжил цэцэглэлтийн боломж энэ Орхоны хөндийд байгаа.

Орхоны хөндийд дэх тэр археологийн судалгаа, олдворын талаар яривал тусдаа маш том, бараг эрдэм шинжилгээний хурал хийх хэмжээний ийм асуудал.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 4 номероос нэмж тайлбарлах уу? С.Зулпхар гишүүний асуултад. Хэн билээ? Н.Нацагдорж.

Н.Нацагдорж: С.Зулпхар гишүүний асуултад хариулъя. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Орхоны хөндий бол Монгол угсаатан, Монгол үндэстний ариун газар. Энэ юугаараа ариун газар вэ гэвэл даргын сая хэлсэн манай Монгол Улсын 7 төрт

улс буюу 5 нийслэл энд байгаа. Газар доороо байгаа. Археологийн олдворуудаар нотлогдсон.

Үүгээрээ ч тэр Орхоны хөндийн 183 мянган га газар дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн, ЮНЕСКО-д бүртгэгдсэн. Одоо 20 дахь жилдээ орж байна. Бүртгэгдээд.

Тэгээд энд шинэ хот байгуулах. Хархорум хот маань өмнө нь ямар байсан бэ гэвэл дэлхийн түүхэнд энэ олон соёл иргэншил, олон шашнууд нэг доор оршин тогтнож, ингэж хот болж амьдарч оршиж байсан. Үүгээрээ тэр түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Өнөөдөр дэлхийд ийм хот ерөөсөө байхгүй. Ерөөсөө байхгүй.

Тэгэхээр энэ бол эв найрамдлын хот. Монгол угсаатны Монголчуудын сэргэн мандалт.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 4 номерын микрофоныг нэмж гүйцээлгээд хариулъя.

Н.Нацагдорж: Тэгэхээр үүний төлөвлөлт ямар байх вэ гэдэг асуулт асууж байгаа юм.

Хот төлөвлөх үйл ажиллагаа Өнөөдөр Улаанбаатар хотоор жишээ аваад үзэхэд Улаанбаатар хотыг яаж төлөвлөх үндсэн төлөвлөлтийн зарчим байхгүй. Хуульчилсан. Төлөвлөлтийн шаардлага байхгүй.

Тийм учраас төлөвлөгч нар үүнийг хуулийн дагуу зохицуулж хийх гэхээр маш олон санаа, маш олон зүйлүүд байдаг учраас, энэ захиалгагүй учраас хийхэд маш төвөгтэй. Одоо хүртэл учраа олж чадаагүй байгаа.

Энэ хуулийн зорилго бол Хархорум хотыг төлөвлөхөөсөө эхлээд хуульчилсан тэр зарчмууд нь байна. Тэр түүхэн байх, эко байх, тэр эрчим хүчний хэмнэлттэй байх гэдгийг хуулиар зааж өгч байгаа. Бүтээн байгуулалтад нь бас яг бүтээн байгуулалтын зарчмуудыг нь зааж өгч байгаа юм.

Тэгэхээр энэ хот бол энэ хууль гарсны дараа төлөвлөлт нь ч тэр хуулийн хүрээндээ, бүтээн байгуулалт нь ч хуулийн хүрээндээ явах ийм эрх зүйн орчин бүрдэх юм.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Одоо С.Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Цаг хугацааны тохиолол 1220 оны цагаан луу жил Чингис хаан Хорезмд нэвтэрч орсон байдаг. Энэ тухай Персийн түүхч Минхаж Аль-Сираж Жужани /Minhaj Siraj al-Din Juzjani/ тэмдэглэлдээ бичсэн байдаг.

Тэгэхээр өөрөөр хэлбэл Хархорум хотыг үүсгэн байгуулах их хааны зарлиг гардаг жил, түүний өмнөх 2 жил 1218 онд Кашкарт нэвтэрсэн. 1220 онд

ингээд томоохон Хорезмыг эзэлсэн. Тэр үеэр түүхэн тэмдэглэлүүдэд Чингис хааны томоохон барилга, байгууламж, хотуудын тухай асуусан асуулт, тухайн үед Туркийн 280 селжүк баянаар удирдуулж байсан Бухарын толгой баячуудаас нь асууж байсан асуулт гээд байдаг.

Тэгээд түүхэн тохиолдлоор 2024 оны хөх луу жил энэ асуудал бас ингэж Улсын Их Хурлын түвшинд яригдаж байгаа юм байна. Өөрөөр хэлбэл 804 жилийн дараа луу жилд суурь нь тавигдсан хот дахиад луу жилд энэ асуудал яригдаж байгаа юм байна.

Тэгээд яагаад үүнийг ярьж байгаа вэ гэхээр бид багаар бодоход 2 мянга илүү жилийн төрт ёсны түүхтэй. Бичмэл бус, одоо Хятадын цагаан хэрмийг бариулахад үйтгэгдсэн хүчийг нь аваад үзэх юм бол 4, 5 мянган жилийн бичгэн бус соёлын түүхтэй үндэстэн.

Тэгэхээр энэ шинээр хот бий болгоно гэдэг чинь өөрөө Европын гүн ухаан дээр хүртэл “полис” гэдэг чинь хот гэсэн үг. “Полиси” буюу бодлого. Хот улс гээд явдаг. Америкийн иргэний дайны жилүүдэд Абрам Линколын хүртэл энэ Капитолийн төсөв гацчихсан байхад дайны хүнд үед хүртэл үүнийг босгох ёстой. Үндэсний эрмэлзлийн эвлэлдэн нэгдэх эв нэгдлийн бэлгэдэл бол хот байдаг юм, хотын шүтээн байдаг юм гэж бүр тодотгож байсан.

Тэгэхээр Хархорум хот босно гэдэг бол өөрөө зүгээр хот байгуулах тухай асуудал биш. Энэ бол шинэ цагт XX-оос XXI зуунд шилжиж байгаа энэ үед олон мянган жилийн түүхтэй нүүдэлчин соёлтой Монголчуудын хувьд өөрийн төрт ёсны дараагийн томоохон тодорхойлолт буюу эрмэлзлийг тодотгох тухай ойлголт.

Тийм учраас энд маш олон татах хүч бий болох ёстой. Татах хүч. Эдийн засгийн татах хүч, итгэл үнэмшлийн татах хүч, соёлын татах хүч, хүн ам зүйн бодлогын татах хүч. Маш олон төрлийн татах хүчийг бид энэ дээр тодотгох ёстой. Тэр утгаараа монгол хэлэнд “үйл хэрэг” гэж үг байдаг. Үүнийг бид ер нь ашиглахаа больчихсон. Одоо 14 мега төсөл л гээд яриад байгаа. Төсөл гэдэг их тийм сүүлд хэрэглээнд орсон. XX зууны үгс үг шүү дээ. Уучлаарай, баярлалаа, бялуу гэдэгтэй хамт орж ирсэн үг.

Ер нь ийм том хэмжээний зүйлийг “үйл хэрэг” гэж бид нэрлэдэг.

Тэгэхээр энэ Хархорум хотын асуудал бол монголчуудын хувьд энэ цаг үеийн асар том үйл хэрэг байх ёстой. Ийм том үйл хэрэгт бас эрх зүйн логикийнх нь хувьд бид тусад нь хууль гаргаад энэ чиглэл дээр бүгдээрээ эрвийх дэрвийхээрээ ажиллах ёстой. Энэ бол зөвхөн У.Хүрэлсүх гэдэг Ерөнхийлөгч зарлиг гаргаад, Монгол Ардын намын санаачилж байгаа зүйл гэж бас харж болохгүй. Энэ бол олон олон төрийн үед, олон олон төрийн зүтгэлтнүүдийн, эх оронч хүмүүсийн санаачилж байсан, сэдэж байсан, сэтгэл зовж байсан, олон олон эрдэмтэн мэргэдийн судалгаагаа зориулж байсан.

Дээрээс нь үнэхээр энэ цаг үед монголчуудын тэр national inspiration гэж олон улсын хэллэгээр хэлж байгаа юм. Үндэсний эрмэлзэл бөгөөд үндэсний тэр итгэл үнэмшлийг бий болгох зүйл. Энэ Нелсон Манделагаас ч харахад, Солонгосын түүхийг ч харахад, Америкийн түүхийг ч харахад ер нь тэр founding fathers буюу үндэслэгч эцгүүдийн түүхийг ч харахад энэ хот улс босгоно гэдэг бол өөрөө асар том үйл хэрэг байдаг. Бид хойд орныхоо түүхийг харахад ч гэсэн, Европын түүхүүдийг харахад ч гэсэн.

Тэгэхээр энэ асуудал дээр их нухацтай хандах ёстой байх. Улсын Их Хурлын Тамгын газрын зүгээс ч гэсэн энэ талаас нь, болох бүтэх талаас нь дэмжих ёстой. Энэ дээр улс төржиж болохгүй. Энэ дээр явцуурхаж болохгүй. Энэ дээр одоо юу гэдэг юм мэдээж олон ургалч үзэл, хандлага, сэтгэлгээ, хүмүүсийн бодол.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: С.Эрдэнэболд гишүүний.

С.Эрдэнэболд: Асуулт дээр явж байгаа юм чинь нэг асуулт асууна.

Тийм. Тэгэхээр энэ бол одоо юу гэдэг юм ачаалал ихтэй үеэр маш хурдан хугацаанд шийдээд яриад явчих гэхээсээ илүүтэйгээр бид энэ дээр аягүй тийм үндэслэлтэй, нухацтай хандаж, тал талаасаа тийм дэмжих сэтгэл зүйтэй яваасай гэж бодож байна.

Тийм ч учраас ажлын хэсэгт байгаа хүмүүсийг аль болох олон талаасаа гүн ухаан, түүх, одоо бүр лингвистик, этимологи талаасаа, аль аль талаас нь шинжлэх ухааны олон уулзвар тал дээр энэ дээр дүгнэлт гаргавал сая тэр гишүүдийн хэлээд байгаа зүйл дээр олон талын мэдлэгүүдийг энэ дээр өрж тавих ёстой байх л гэж бодож байгаа.

Тэгээд нэг зүйлийг хэлэхэд ер нь энэ төсөл дээр маш том зоригтой байх ёстой. Дээрээс нь тэр “татах хүч” гэдэг үгийг ашиглаач.

Дээрээс нь тэр “төсөл” гэдэг хэмжээнд биш, “үйл хэрэг” гэдэг үгийг ашигламаар байна. Монгол хэл чинь баян хэл шүү дээ. Тэгээд энэ үгүүдийн эргэлтэд оруулаад яваач ээ.

Асуулт нь энэ “үйл хэрэг” гэдэг үг ч гэдэг юм уу, энэ үгүүдийг цаашид нь хэвшүүлээд явах бо боломжтой юу гээд асуучихъя.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах юм? Ажлын хэсэг 5 номер. Г.Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Баярлалаа. С.Эрдэнэболд гишүүн бас их чухал асуулт асуулаа. Энэ ард түмний нийтийн хүсэл эрмэлзлийг хууль болгож тогтоох нь л хууль тогтоогчдын эрхэм зорилго, үйл хэрэг мөн.

Тэгэхээр энэ үйл хэрэг маань жишээлбэл Тамгын газрын дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа нэг юм нь, хуулиа бүрэн гүйцэд хараагүй байж магадгүй гэж байгаа юм нь бол байна шүү дээ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1-д хот нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг бүхий эдэлбэр газар, эдийн засаг, дэд бүтэц, нийтийн эрх зүйн этгээд мөн гээд заачихсан.

Тэгэхээр хуулиар тусгайлан эрх, үүргийг нь олгож болно гээд заачихсан байхгүй юу.

Тэгэхээр энэ Хархорум хотод эртний нийслэлийнх нь хувьд ч гэсэн ийм онцгой статусыг нь үндэслээд тусдаа тэр сэргээгдэх эрчим хүчний хот байх, эко хот байх, түүхэн хот байх энэ эрх зүйн үндсүүдийг л тусгай хуулиар олгож байгаа.

Тэгэхээр бусад хуулиас зөрчилдөж болно. Тэгэхээр энэ хуулиа ингэж байж энэ шинэ хот байгуулахгүй бол манай энэ Улаанбаатар хот, үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, Улаанбаатарын агаарын бохирдол, хөрсний бохирдол ямар хэмжээнд хүрсэн. Улаанбаатарт мянган хөрөнгө оруулалт хийгээд улам л төвлөрөөд л байх юм бол улам л асуудал нэмэгдээд л байна. Энэ шинэ төвлөрөл бий болох зайлшгүй шаардлага, нийтийн үйл хэргийн үүднээс энэ үйл хэргийг эхлүүлж байгаа ийм түүхэн л ажил.

Яг энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1-ийг л аваад үзчих юм бол Улсын Их Хурлын Тамгын газрын эрх зүйн дүгнэлт баахан хууль зөрчөөд байгаа юм шиг ийм ойлголт өөрөө аяндаа өөрчлөгдөнө.

Ийм учраас энэ үйл хэрэг талаасаа харж энэ ажлыг болох утга талаас нь, нийтийн эрх ашиг талаасаа бодож явахгүй бол сая ч гэсэн гишүүд бас баахан хууль зөрчөөд байгаа юм шиг ойлголт өгөх юм бол буруу болчихно шүү гэдгийг л би онцолж, зөв үйл хэрэг бол ингээд л хэрэгжээд л явах ёстой. Одоо хот байгуулах шаардлагатай юу шаардлагатай гэдгийг л.

Тэгээд нэмж ганц зүйл хэлэхэд эртний Луут хот Хархорумд, эртний нийслэл Хархорум, Жужаны Мумо хот, Уйгарын Хар балгас буюу Хар хот гээд одоо эртний нийслэлүүд яагаад тэнд байгуулагдаад байдаг байсан юм. Орхоны хөндийн түүх дурсгал, түүхэн шаардлага өөрөө тэнд хот байгуулах түүхэн болон нийгэм, эдийн засгийн зайлшгүй шаардлага, үйл хэргийг нотолж, харуулж байна. Тэнд хөрөнгө оруулалт босгох маш олон өргөн боломжууд байна. Баруун аймгийн, төвийн бүсийн, хангайн бүсийн бүх нүүдэл суудал тэнд шинэ хотоо дагаад аялал жуулчлал, эдийн засгийн шинэ сэргэлт бий болох жинхэнэ агуулга энд байна.

Казакстан Улс Астана хотыг шинээр байгуулаад л эдийн засаг нь хэд дахин тэлэв. Бараг ижил гараанаас эхэлсэн улсын эдийн засгийн хөгжил ямар

түвшинд байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн эдийн засгийн цар хүрээ яаж тэлж байна.

Ийм учраас энэ бол үнэхээр агуу том үйл хэрэг мөн. С.Эрдэнэболд гишүүний санаатай санал нэг байна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Одоо Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Хууль санаачлагч нар, Ерөнхийлөгч байдаг юм уу, Засгийн газар байдаг юм уу орж ирээд ярихдаа нэг үгийг их хэрэглэдэг болчихсон. Аль ч хууль, төсөв ч бай, бусад зүйл дээр ч бай.

Үүнийг тогтоох нь Их Хурлын бүрэн эрх. Та нар яаж ч баталж болно гэдэг үг. Яаж ч баталж болох юм бол бодсон санаснаас чинь өөрөөр батлах гээд хэт өөрчлөөд аль ч үгүй болговол хуулиа татаад авчихдаг л болох хэрэгтэй болчхож байгаа байхгүй юу.

Тийм болохоор энэ хуулиа санаачилж байгаа, үүнийгээ ингээд бодит хууль болгоод, үр дүнд хүргээд, үйл хэрэг болгоод, тэр үзэл санааг нь тодотгоод, улс үндэстэнд, ард түмэнд бүгдэд нь сайн зүйл болгохын тулд энэ зүйлийг нь хасах юм бол энэ хуулийн амин сүнс нь алга болчих юм. Энэ зүйлийг оруулахгүй бол үүнийг өөрчлөх юм бол энэ хууль батлагдсанаараа зүгээр л хоосон цаас болж хувирна гэдэг үгийг хэлж чаддаг баймаар байгаа юм.

Их Хурлын гишүүдийн бүрэн эрх. Та нар энэ хуулийг өөрчлөөд одоо ямраар ч баталж болно гэдэг үгийг болж өгвөл бага хэрэглэмээр байгаа юм.

Нөгөөдөх нь эргээгээд Их Хурал дээр орж ирээд янз бүрийн гоё олон сайхан утга санаа дэлгэрээд, баахан чимэг зүүлт зүүчихдэг. Тэр нь амьдралд угаасаа тэр хууль хэрэгжих боломжгүй болгочихдог.

Нөгөө хуулиа хэрэгжүүлэх гэхээр бусад хуультай зөрчилдөнө. Доторх хоорондох зүй зохистой байдал нь алдагдчихсан байдаг. Үүнийг нэгдүгээрт хууль санаачлагчид анхааруулаад хэлчихье. Өөр хууль төсөв хэлэлцэж байх үед ч гэсэн ярьж байсан. Иймэрхүү үгүүд. Тийм болохоор дахиж ийм байдлаар хандахгүй байхыг. Мэдээж Их Хурлын хууль тогтоох халдашгүй бүрэн эрх байж байгаа. Гэхдээ санаачлагчийн хууль явж өгөөгүй тохиолдолд санаачлагч хуулиа татдаг байх ёс доо л гэдэг зарчмын асуудал хэлж байгаа юм.

Дараа нь Хархорум хот. Монголчууд Хархорум хотыг шинээр дахин байгуулна гэхэд ер нь эсэргүүцэж үг хэлэх юм уу, кноп дарах Их Хурлын гишүүд бараг гарахгүй дээ. Дэмжихгүй байхын аргагүй хууль.

Тэгэхдээ энэ хуулиар манай Хархорум хот чинь яг ямар хот болох юм? Улсын нийслэл болох гээд байгаа юм уу? Төрийн захиргааны төв байгууллагууд

нь нүүж очих гээд байгаа юм уу? Аялал жуулчлалын уламжлалын хот болох гээд байгаа юм уу? Үйлдвэрийн хот болох юм уу? Энэ тухайд нь тэр хэв шинж, хотын тэр хэв шинж нь ямар байх юм? Яаж төсөөлж байгаа юм? Зүгээр аялал жуулчлал явдаг л хот байх юм уу? Тэгвэл хэдэн хүн амьдрах юм? Үйлдвэрийн бүстэй байх юм уу, бүсгүй байх юм уу? Засаг захиргааны улсын төрийн захиргаа.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Асуултад хариулах вэ? Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Н.Нацагдорж: Б.Батбаатар гишүүний асуултад хариулъя.

Таны санал яг зүйтэй. Хууль яагаад гарах гээд байгаа юм бэ. Яагаад хууль ийм яаралтай байх хэрэгтэй юм бэ.

Түрүүний хэлсэн бас бүх нийтийн үйлс гэдэг. Энэ бол зөвхөн Монголд амьдарч байгаа монгол иргэдийн үйлс биш бүх монгол угсаатны үйлс. Дэлхийн монголчуудын үйлс болох юм. Яагаад гэвэл үүнийг маш их сонирхож байгаа. Дэлхийн монголчууд. Энд оролцох юм сан гэсэн. Дэлхийн хөрөнгө оруулагч нар.

Энэ юугаар харагдаж байна вэ гэвэл олон улсын уралдаан зарлахад дэлхийн 54 улсын 428 архитектурын баг бүртгүүлсэн байгаа. Гуравхан сарын хугацаанд. Тэгээд үүний 75 баг нь яг Хархорумд зориулж төлөвлөлт хийсэн. Үүнээс 36 нь Монгол Улсад өөрийнхөө зардлаар ирж үзэсгэлэнгээ гаргасан байдаг юм.

Тэгээд үүнээс харахад Хархорум гэдэг бол ерөөсөө дэлхийн үйлс болох юм байна. Энэ брэнд юм байна гэдэг нь ойлгомжтой болж байгаа юм.

Тэгээд энэ хотын үндсэн төрх ямар байх юм бэ гэвэл ер нь “Алсын хараа-2050” дээр бол энэ нийслэлийн баримжаатай байна гэдгийг заагаад өгчихсөн. 2030 он гэхэд тийм тийм зүйлүүдийг нь хийсэн байх ёстой гээд заагаад өгчихсөн байдаг.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт ерөнхийдөө энэ чинь эртний нийслэл байна. Эртний нийслэлээ сэргээнэ. Тэгээд төр, захиргааны хот байна гээд заагаад өгчихсөн.

Зүгээр хотын үндсэн төлөвлөлт, концепц боловсруулахад олон улсын ч тэр, дотоодын бид нарын мэргэжилтнүүдийн судалгаагаар хийсэн төлөвлөлтийн хүрээнд ч тэр энэ бол үндсэндээ 5 тэргүүлэх чиглэлтэй байхаар байгаа.

Энэ мэдээж том аялал жуулчлал. Аялал жуулчлалаа бид хөгжүүлэх ёстой. Энэ бол маш олон Монголын эртний түүхүүд тэнд оршиж байгаа. Үүнийгээ илрүүлж, үүнийгээ олон улсад сурталчлах.

Мөн өндөр технологийн салбарыг тэнд хөгжүүлнэ. Өндөр технологид түшиглэсэн эрүүл мэнд, боловсролын салбарыг тэнд хөгжүүлнэ. Мөн өндөр технологид түшиглэсэн хүнсний хөнгөн үйлдвэрийн салбаруудыг бас хөгжүүлнэ.

Мөн гадаад харилцааны салбарыг хөгжүүлнэ гэсэн ийм чиглэлүүдээр төлөвлөгдөж байгаа. Ер нь бол. Үндсэн чиглэлүүд нь. Энэ бол тогтвортой хөгжих үндсэн 5 чиглэл байгаа юм. Бие биеийгээ нөхөж байж болох 5 чиглэл гэсэн үг. Ийм төлөвлөлтийн концепц үндсэндээ хийгдээд явж байгаа.

Дахиж хэлэхэд энэ хуулиар заагдсан үндсэн шаардлагууд, төлөвлөлтөд тавих шаардлагууд бүтээн байгуулж тавих шаардлага үүний дагуу цаашаагаа төлөвлөх бүтээн байгуулах үед тэр архитектуруудын, хот төлөвлөгч нарын үндсэн оюуны чадавх энэ заалтад түшиглэж энэ хүрээндээ баяжиж явна л гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Болсон уу? Б.Батбаатар гишүүн. Дараагийн гишүүн Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Би хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Зарчмын хувьд дэмжиж байгаа.

Хэлэлцэх эсэх шийдсэний дараа хэлэлцүүлгийн шатад ажлын хэсэг гарч ажиллах байх. Ажлын хэсгийн хүрээнд хэд хэдэн асуудлыг анхаарч авч үзээсэй гэсэн хүрээнд дараах хэдэн асуудлыг ярья.

Нэгдүгээрт, газрын харилцааны асуудал байгаа. Энэ хуулийн тухайтад 10 дугаар зүйлээр хотын газар зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулсан байгаа. Нэг зүйлээр.

Тэгэхээр бид одоо 2002 оны батлагдсан Газрын хуулиар өнөөдөр хот, сууриныхээ харилцааг зохицуулаад, өнөөдөр Улаанбаатар хотын газрын харилцааны асуудал ямар хэмжээнд хүрсэн бэ гэдэг бол энэ газрын хуулиас нэлээн холбоотой.

Тийм ч учраас Газрын хуулийг өнгөрсөн парламентын үед бас багц хууль хэлбэрээр 5 бие даасан хууль хэлбэрээр Улсын Их Хурал өргөн бариад хэлэлцэхийг нь шийдээд явж байсан. Энэ төсөл одоо Засгийн газар дээр байгаа. Бэлэн байгаа.

Мөн Хот байгуулалтын тухай хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн баригдаад, мөн хэлэлцүүлгийн шатад байж байгаад буцчихсан. Энэ төслүүдийн сайн талуудыг энэ газрын харилцааны хэсэг дээр авч ашиглаасай гэсэн ийм бодолтой байна.

Яагаад гэхээр ерөөсөө 2002 оны газрын хуулийн гол заалтуудыг яг тэр чигээр нь биччихсэн байгаа юм. Төсөв сонгон шалгаруулах зарчмаар шийднэ.

Хамгийн гол асуудал нь газар чөлөөлөх журмыг нөхөн олговортойгоор чөлөөлөх журмыг Засгийн газар батална гээд биччихэж байгаа юм.

Тэгэхээр өчигдөр Үндсэн хуулийн 2024 оны 04 тоот дүгнэлтийг манай Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцсэн байгаа юм. Энэ Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцсэн цэцийн дүгнэлтэд 24 дүгээр хуудсанд хуульд заасан үндэслэл журмаас гадуур эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж Үндсэн хуульд тавьсан энэ заалтыг тайлбарласан байгаа юм. Үндсэн хуулийн цэц тайлбарласан.

Энэ дотор 3 хүрээнд үүнийг ойлгоно.

Нэгдүгээрт, журмаар хүний хувийн өмчийн хэрэгт халдахгүй гэдгээ шууд хэлчихсэн байгаа юм. Хэрэв ингэвэл цаашдаа Үндсэн хууль зөрчсөн гэж үзнэ гэсэн юм шууд хэлчихсэн юм. Журам баримтлахгүй шүү гээд.

Тийм учраас үүнийг чөлөөлөх харилцааг хуульд өөрт нь бичиж таарч байна.

Тэгэхээр өөрт нь бичих хууль нь уг нь өмнөх юугаар бол Улсын Их Хуралд бас бие даасан хууль хэлбэрээр өргөн баригдсан юм. Тэр утгаар нь би тэндээс аваад явчихвал дараа нь нөгөө цэцийн асуудал болохгүй байх талаас нь нэгдүгээрт бодож байгаа юм.

Энэ дээр ер нь 3 журам Засгийн газар батлахаар хийсэн байгаа юм. Нэгдүгээрт саяын ярьсан бүтээн байгуулалтын төсөл сонгон шалгаруулах журмыг. Энэ уг нь хуульд нь бичигдмээр журам байгаад байдаг. Саяын хэлсэн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут. Б.Энхбаяр гишүүний.

Б.Энхбаяр: Мөн 25 дугаар зүйлд заасан хот хөгжүүлэх сантай байна гээд. Энэ сангийн журмыг нь болохоор бас Засгийн газар батлахаар хийчихсэн байгаа.

Тэгэхээр одоо сая бид улсын төсвийг би ажлын хэсэг дээр яриад 2025 оны төсвийг дагалдуулж гаргасан Улсын Их Хурлын тогтоол дээр цаашид энэ сангуудын ажиллах журмыг хуульд өөрт нь бичих чиглэлийг Засгийн газарт өгсөн юм.

Тийм учраас түүгээрээ буюу Засгийн газар өөрөө журмыг нь батлахаар хуульчилсан сангуудын хөрөнгийг царцаах зарчим баримталчихсан гэсэн үг. Тийм сангуудын хөрөнгийг сая 2025 оны төсвийн хууль дээр бид царцаачихсан юм. Зарцуулахгүй гээд.

Тэгэхээр энэ явагдаж байгаа сүүлийн үеийнхээ юман дээр ажлын хэсэг бас анхаараад боловсронгуй болоод тэгээд хэлэлцэх эсэхийг бас дэмжиж.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Б.Энхбаяр гишүүний асуултад Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Хэлэлцүүлгийн явцад Б.Энхбаяр гишүүний саналуудыг анхаарна.

Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдана. Гэхдээ нэг зүйлийг хэлэхэд энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар нөгөө эдэлбэр газрыг эзэмших, ашиглах, өмчлөх асуудлыг зохицуулсан байдаг. Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар бол өмчлөх тэр эрхийг бол янз бүрээр хөндөж байгаа юм бол байхгүй. Зөвхөн эзэмших, ашиглалтыг л зохицуулсан. Өмчлөхтэй холбоотой харилцааг энэ дээр зохицуулаагүй.

Тэр хотын газар зохион байгуулалт буюу яг тэр хотын хөгжлийн төлөвлөгөөнд нийцсэн саналыг захирагчийнх нь саналыг үндэслээд заавал зөвлөлөөр оруулж шийдэж байгаа.

Мөн эзэмших, ашиглах эрхийг л хотын захирагч журмаа гаргаад олгож байгаа болохоос биш өмчлөх эрхэд халдаж байгаа, өмчлөх эрх рүү орж байгаа зүйл байхгүй.

Мөн энэ хуулийн 10.6 дээр Засгийн газрын шийдвэрээр улс, хотын төсвийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг чөлөөлөх журмыг Засгийн газар батална гээд. Энэ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр өөрөө Хархорум хот бол Засгийн газартай харилцаад явах учраас одоо ч гэсэн бид Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын дэргэд авчраад нутгийн өөрөө удирдах байгууллагууд хуралдаад нөгөө газар нэгжийн шийдвэрээ гаргаад, тэрийг нь засгаар нэгдсэн тогтоол гаргаж баталдаг.

Хуучин нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуралдаад л ингээд Засаг дарга захирамж гараад шийдээд байдаг байсан. Одоо Засаг дээр энэ газар, нэгжийн байршлуудыг нь иргэдийн Хурлаараа оруулчхаад засаг руу явуулаад нэгдсэн байдлаар шийдэж явсанаас хойш газар олголт харьцангуй цэгцэрч байгаа шүү дээ.

Тийм учраас ер нь төсөл хэрэгжүүлэх гэж байна уу, эсвэл том бүтээн байгуулалтын ажил өргөжиж байна уу, гаднын хөрөнгө оруулалт байна уу ч гэсэн газар ашиглах, эзэмших шаардлагатай бол мэдээж Засгийн газраар оруулаад хуралдаанаараа шийдвэрлээд явна.

Тэгээд ер нь бүгдээрээ Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль нэгэнт өнгөрсөн парламент баталсан.

Тэгэхээр энэ хуулийг амилуулах, хэрэгжүүлэх ийм шаардлагатай байгаа. Энэ ч утгаараа яг хууль дээрээ ийм давхардал хийдлүүд үүсчихсэн, бэлтгэл ажлыг хангуулах зайлшгүй шаардлагууд бас байгаа шүү. Хот, тосгоны хууль дээр.

Зүгээр Хархорум хотын бүтээн байгуулалтын хөгжлийг дэмжих энэ хууль бол өөрөө ийм гарцыг л нээж өгч байгаа л даа.

Тэгэхээр яах вэ, уртдаа мэдээж энэ чинь төлөвлөлтгүй хот биш, анхнаас нь энэ хотыг 500 мянган хүнтэй хот байна гэж төсөөлж бид төлөвлөж байгаа байхгүй юу. Түүнээс биш угаасаа хүн амьтан амьдрахгүй байна, барилга, байгууламж баривал бариг гээд ингээд хаячихвал энэ бол зүгээр л дахиад нэг шинэ гэр хороолол үүсэх эрсдэлтэй шүү дээ.

Тийм учраас хурдан хугацаанд үүнийг яг төлөвлөгөөнийх нь дагуу хөгжүүлэх ёстой. Тэр ч утгаараа өнгөрсөн хугацаанд Хархорум хотын захиргаа нэлээд олон зургуудаа хийсэн. Хөрсний судалгаа, тэгээд л янз бүрийн нэлээн олон ажил хийсэн. Олон улсын нээлттэй сонгон зарлаад, ерөнхий төлөвлөгөөгөө бэлдсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид цаашдаа ер нь том утгаар нь энэ хотыг төлөвлөнө. Хархорум хотыг ирээдүйд 500 мянган хүнтэй хот болно гэж төсөөлж энэ хуулийг анхнаас нь шаардлагуудыг ч гэсэн өндөр тавьж хийх ёстой.

Тэгээд одоогийн төлөвлөгдсөн төлөвлөгөөний дагуу яг бид тэрийг виртуал орчин дээр гаргаж харж байгаа. Тийм учраас 500 мянган хүнтэй хот байна. Ийм том хот бий болно гэдгээр нь.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Б.Энхбаяр гишүүн нэмэлт 1 минут.

Б.Энхбаяр: Би дараа нь хуулийн ямар нэгэн саадгүйгээр хот маань сайхан хурдан баригдчихаасай гэдэг утгаар л хэлээд байгаа юм. Нөгөө талдаа тэнд хувийн өмчийн эрх Үндсэн хуулиас гадуур зөрчигдөөд асуудал үүсчих вий гэдэг утгаар хэлээд байгаа юм.

Яагаад үүнийг яриад байна вэ гэхээр 2013 онд хотын дарга Э.Бат-Үүл нийслэлийн иргэдийн Хурлын дарга н.Баттулга нар хүний эзэмшиж байгаа, өмчилж байгаа газрыг нөхөн олговортойгоор хурааж авах журам гаргаж байгаад гэр хорооллын барилгажилтыг эхлүүлээд, энэ нь Үндсэн хуулийн зөрчил болоод фэйлдчихсэн юм. “Эмнести Интернэйшнл”-ээс дүгнэлт гараад. Тухайн үед Нийслэлийн захиргааны хэргийн шүүх энэ өөрөө Үндсэн хуулийн зөрчил байхыг үгүйсгэхгүй. Тэгэхдээ захиргааны шүүх иргэдийн Хурлын шийдвэрийг хянахгүй гэдгээрээ л, Үндсэн хууль зөрчсөн шийдвэрийг хянахгүй гэдгээрээ л асуудал

явсан болохоос биш энэ Үндсэн хууль зөрчсөн гэдэг бол бүх түвшиндээ яригдсан юм.

Засгийн газар бол.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут. Б.Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Тэгээд Засгийн газар бол иргэдийн хурал шиг Үндсэн хуулийн цэцийн хяналтын субъект. Нөгөө иргэдийн хурал бол Цэцийн хяналтын субъект биш байгаад байгаа юм. Тэрүүгээрээ мултарсан байхгүй юу. Э.Бат-Үүл. Тэр үед.

Тэгэхдээ төсөл нь фэйлдсэн юм. Засгийн газар бол шууд Үндсэн хуулийн цэцийн хяналтын субъект байхгүй юу.

Тэгэхээр би эсрэгээрээ Засгийн газраа ухаандаа аврах талаас нь яриад байгаа байхгүй юу. Хуульд нь биччихвэл хуулийнх нь төсөл нь ороод ирчихсэн байхгүй юу. Энэ чинь нөгөө эзэмшил, ашиглаж байгаа, өмчилж байгаа газрыг нөхөн олговортойгоор том бүтээн байгуулалт, чөлөөлөх энэ хуулийн төсөл чинь бол Улсын Их Хуралд өргөн баригдчихсан шүү дээ. Бие даасан хэлбэрээр.

Тэгэхээр тэгж тодорхой болгож авахгүй бол наадах чинь үнийг нь тохирох, тэр улсын тусгай хэрэгцээ гэдэг үндэслэл, шаардлагаасаа эхлүүлээд аягүй тийм. Ядаж хүндээ мэдэгдэх ёстой.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Үг үү, санал уу? Санал байна.

Хуулийн төсөл үзэл баримтлалтай холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу? Саналаа өгнө үү. Г.Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Г.Уянгахишиг гишүүн цаг чинь яваад байна.

Г.Уянгахишиг: Би богинохон үг хэлнэ. Тийм.

Тэгэхээр Хархорум хотыг хөгжүүлэх, байгуулах. Тийм ээ. Одоо бид Хархорум хотыг байгуулах, төлөвлөгөөг нь гаргах⁸ бүтээн байгуулалтыг нь дэмжих талаар ярилцаж байгаа шүү дээ.

Тэгэхээр хуулийн төслийг зайлшгүй хуулиар зохицуулах шаардлагатай асуудлууд байгаа учраас, үйл ажиллагааг нь цаашаагаа цаг хугацаа алдалгүйгээр үргэлжлүүлэх гэдэг талаасаа энэ хуулийн төсөл өргөн баригдаад явж байгааг ойлгож байна.

Тийм учраас энэ хуулийн төсөл өөрөө дотроо Хархорум хотын эрх зүйн байдлын тухай асуудлыг агуулахгүй байгаасай. Одоо түрүүн Г.Занданшатар

даргын хэлж байгаа, мөн төслийн багийнхны хэлж байгаачлан, хууль санаачлагчийн зүгээс ч тайлбарлаж байгаачлан энэ бол нэг удаагийн хууль гэж тайлбарлаж байгаа.

Тийм учраас энэ өөрөө нэршлээс авхуулаад төлөвлөлт, бүтээн байгуулалтыг дэмжих гэдэг талаасаа хэлэлцэгдэх болов уу гэдэг үүднээс хэлэлцэх эсэхийг дэмжих саналтай байгаа юм.

Түүнээс биш бид өнөөдөр яг ийм агуулгаар жишээлбэл Хархорин хотын эрх зүйн байдлыг зохицуулж болохгүй. Яг тэр талаасаа төлөвлөгөө, бүтээн байгуулалтыг дэмжих талаасаа эхний шаардлагатай үйл ажиллагаануудыг зохицуулах эрх зүйн үндсийг нь бий болгох, орчныг нь бий болгох талаас энэ хуулийн төслийг яг одоо ажлын хэсгийн хүрээнд Их Хурлаас төсөл дээр ажиллах болов уу гэж харж байгаа.

Нөгөө талаасаа Их Хурлын Тамгын газраас гаргасан хуулийн дүгнэлт дээр ч гэсэн ер нь тусгаж оруулж ирсэн. Тийм ээ. Яг энэ хуулийн өөрийнх нь нэршил, буцаагаад зохицуулах гэж байгаа асуудлаас илүү зохицуулалтаа нийцүүлээсэй. Мөн бусад хуулиудтай уялдуулж оруулж ирээсэй гэдэг ийм санал, дүгнэлт гарсан байгаа.

Үүнийг бид заавал яг хуульдаа зөрчилтэй байх ёстой буюу зөрчсөн ч гэсэн хийнэ гэдэг талаасаа биш, харилцан уялдуулаад цаашаа явах талаасаа бас ажлын хэсэг анхаарч ажиллах байх.

Тэгээд ямар ч байсан энэ хуулийн төслийг яаралтайгаар хэлэлцэхгүй байх гэдэгт итгэлтэй байгаа. Энэ дээр бид нэлээн сайн сууж ажиллах ёстой төсөл байна гэж харж байгаа шүү. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. О.Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Хархорин хотыг ер нь нэг хот болгох ёстой гээд би өөрөө гарын үсэг цуглуулаад явж байсан хүн байгаа юм.

Тэгээд өнөөгийн Хархорин суманд оршин сууж байгаа 5 мянга гаруй иргэдээс гарын үсэг аваад энэ нийслэл хот болох ёстой, хотын статустай болох ёстой гээд явж байсан.

Тэгээд өнөөдөр орж ирж байгаа хуулийн төсөл дээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хянахдаа ер нь өнөөдөр тэр бүс нутагт оршин сууж байгаа хүмүүс. 20 мянган хүн байгаа. Тэнд. Энэ хүмүүсийн эрх ашиг яах вэ гэдэг зүйлээр бас харсан юм.

Тэгээд би бас ажлын хэсгийнхээ гишүүдэд, ажил хариуцсан хүмүүстээ ер нь тэнд бол ажил явагдах ёстой. Монгол Улс эртний нийслэлээ сэргээх ёстой.

Тэгэхдээ уугуул нутагт оршин сууж байгаа тэр 20 мянган хүний асуудлыг байнга анхаарч бид бодож байх ёстой шүү. Хот байгуулна гэдэг том ажил, нүсэр ажил. Тийм ч учраас бид энэ хуулийн төсөл санаачлаад явж байгаа. Энэ их нүсэр тэр ажлын хажуугаар тэр нутагтаа оршин сууж байгаа, эх нутагт эх нутгийнхаа эзэн болсон тэр хүмүүсийн эрх ашгийг ямагт бодож байх ёстой шүү гэдэг зүйлийг хэлж захъя. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт. Хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Ирц хүрч байна уу? Арвуулаа өгөхөд болохоор байна гэж байна.

Яг энэ цаг үед Ардчилсан нам, Ардын намын бүлгүүд бас хуралдаж байгаа учраас гишүүд хоёр талд гүйгээд байгааг зөв ойлгоорой.

Тэгэхдээ ирц хүрч байна. Санал хураалт явуулъя.

1.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалт.

10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Дээр нь Н.Номтойбаяр гишүүн, Ц.Туваан гишүүн, өөр хэн билээ. Дэмжсэнд тооцсоноор бүртгээрэй гэсэн байгаа.

2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хурааа. Санал хураалт. /алх цохив/

9 гишүүн, 52.9 хувиар дэмжигдлээ.

3.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

17 гишүүн дэмжиж, 58.8 хувиар дэмжигдлээ.

4.“Хархорум хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

52.9 хувиар санал дэмжигдлээ.

5. “Хархорум хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулна.

Гурав дахь асуудал. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Гишүүд болоогүй шүү. Одоо сүүлийн асуудал.

**Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд
маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих
нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай эсэх асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоол.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэр гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн. 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт цэцийн эцсийн шийдвэр нь гармагц хүчин төгөлдөр болно гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1-д Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу цэцийн тогтоолоор хууль, тогтоолын зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгосон бол Улсын Их Хурал хууль, тогтоолд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. 87.3-д Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзвэл Байнгын хороо хууль, тогтоолд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

Тухайн төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 15 дугаар зүйлд Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээг зохицуулсан бөгөөд 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ гэсэн заалтыг бүхэлд нь хүчингүй болгосон.

Хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж, түүнийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэнэ гэж цэцийн маргааныг хянан шийдвэрлэнэ гэж цэцийн маргаан хянан хянан шийдвэр шийдвэрлэх ажиллагааны хүрээг ямар нэг хугацааны хязгаарлалтгүйгээр зохицуулсан зохицуулалт байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасны дагуу хууль, тогтоолд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй байна гэж үзсэн байна.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2024 оны 02 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг хүчингүй болсонтой холбогдуулан хууль тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ. /алх цохив/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар тогтоолтой холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 45 минут үргэлжилж, 15 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД